# Эцэг эх, сурагчийн мөрдөх журам
# Ахлах, Дунд Сургууль 2024-2025




*Хан-Уул дүүрэг, Зайсангийн 11-р хороо*
*Шуудангийн хайрцаг 2365, Төв шуудан*
*Улаанбаатар, 15160 Монгол Улс*
*Утасны дугаар: (976-11) 348888*
*www.asu.edu.mn*

***Америк дунд сургууль***
***"Ирээдүйн Удирдагчид"***

**Гарчиг**

**I. УАС-н зорилго** **3**
А. Алсын хараа болон зорилт 3
B. Сурагчийн эзэмших чадварууд (ESSOs) 3
**II. 2024-2025 оны хичээлийн жил** **4**
А. Сургуулийн календарь - Ахлах, дунд сургууль 4
B. Хичээлийн хуваарь 5
**III. Сургалтын Бодлого** **6**
А. Хичээлээ шударгаар хийх 6
B. Хичээлийн дүн, үнэлгээ 6
C. Дүн 6
D. Гэрийн даалгавар 7
E. Анги дэвших 7
F. Олон нийтийн ажил 7
G. Хичээлийн дараах хөтөлбөр: 8
H. Valedictorian болон Salutatorian төгсөгч сонгох 8
**IV. Хичээлийн ирцийн бодлого** **8**
B. Засгийн газрын шийдвэрээр сургууль хаах 9
C. Гэрийн багш 9
**V. Гар утас, цахим хэрэгсэл ашиглах** **10**
**VI. Дүрэмт хувцасны журам** **10**
А. Хөвгүүдийн дүрэмт хувцас 10
B. Охидын дүрэмт хувцас 11
C. Сурагчийн үнэмлэх 11
**VII. Өдрийн хоолны төлбөр** **12**
**VIII. Яаралтай үед холбоо барих** **12**
**IX. Сурагчийн шүүгээ** **12**
**X. Хаясан гээсэн зүйлс** **12**
XI. Эцэг эх сургуулийн хамтын ажиллагаа 13
А. Эцэг эхийн зүгээс санал хүсэлт гаргах 13
B. Сурагчийн зүгээс санал хүсэлт гаргах 13
C. Эцэг эхийн уулзалт, санал хүсэлт 13
D. Эцэг эхийн сайн дурын оролцоо 13
**XII. Хориотой зүйлс** **13**
**XIII. Сургуулийн автобус үйлчилгээний журам** **14**
А. Сургуулийн үүрэг 14
B. Эцэг эхийн үүрэг 15
C. Сурагчийн үүрэг 15
D. Жолоочийн үүрэг 16
**XIV. Хичээлийн хэрэгсэл** **16**
А. Ном сурах бичиг 16
B. Бусад хэрэглэл 17

**XV. Сургуулиас зохиох аялал** **18**
**XVI. Сурагчийн ёс зүйг хянах хөтөлбөр (CICO Check-in Check-Out)** **19**
**XVII. Сурагч төвтэй сургалтын орчин** **20**
A. Сурагчийн ёс зүйн хэм хэмжээ 20
B. Сурагчийг сургуулиас хасах 21
C. Сургуулийн бүртгэлээс (автоматаар) хасах журам 21
**XVIII. Сургалтын албаны ажилтан ба ахлах сургуулийн зөвлөх** **22**
A. Сургалтын албаны ажилтнууд 22
B. Ахлах сургуулийн зөвлөх багш 22
C. Сургуулиас гарах хүсэлт 22
D. Төгсөгчдын гээгдсэн дипломыг нөхөн олгох хүсэлт 22
E. Дүнгийн хуулга, дагалдах материал 22
**XIX. Технологи, Интернет хэрэглээ** **22**
**XX. Хавсралт - Маягт болон бодлогууд** **23**
ХАВСРАЛТ А: Сургуулиас чөлөө авах маягт – Ахлах дунд сургууль 23
ХАВСРАЛТ Б: Маргаан шийдвэрлэх журам 24
ХАВСРАЛТ В: Сурагчийн ёс зүйг хянах хөтөлбөрийн (CICO) Хуудас 25
ХАВСРАЛТ Г: Олон нийгмийн сүлжээ ашиглах удирдамж (Сошиал Медиа) 26
ХАВСРАЛТ Д: Гэрэл зураг, видео бичлэг ашиглах зөвшөөрөл 28
ХАВСРАЛТ Е: Хүүхэд Хамгааллын бодлого 29
ХАВСРАЛТ Ё: Student Check-out Form 2024-2025 37
ХАВСРАЛТ Ж: Ахлах дунд сургуулийн хөгжмийн зэмсэг түрээслэх 41
ХАВСРАЛТ З: Америк Дунд Сургуулийн Биеийн Тамирын Тэнхимийн Зорилго ба Шаардлага 43
ХАВСРАЛТ И: Сургуулийн орчинд дотно үерхлийн сэтгэл хөдлөлөө зүй зохистой илэрхийлэх 48

# I. УАС-н зорилго

## A. Алсын хараа болон зорилт

**Бидний алсын хараа:**

Америк дунд сургууль нь сурагчдынхаа эрдэм мэдлэг, бие бялдар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, сурч боловсрох хүсэл эрмэлзлийг дэмжих, мэдлэг эрэлхийлэхэд өдөөгч хамт олон байх болно.

**Бидний зорилт:**

Америк дунд сургууль нь сурагчдаа эрдэм боловсролтой, ухаалаг дүгнэлт хийх чадвартай, эерэг хандлагатай, өндөр ёс зүйтэй, амьдралаа утга учиртай залж чиглүүлэх иргэд болж төлөвшихөд тусална. Бид сурагчдын бие даасан хандлагыг дэмжсэн, шаардлага өндөртэй сургалтын хөтөлбөрөөрөө дамжуулан сурагчдаа олон улсын их дээд сургуульд амжилттай элсэн суралцаж, даяаршиж буй нийгмийн үнэ цэнэтэй иргэд болоход бэлтгэнэ.

## B. Сурагчийн эзэмших чадварууд (ESSOs)

*Америк дунд сургуулийн сурагч нь:*

**Сурч боловсрохыг эрмэлзэгч байх…**

- Олж авсан мэдлэг, мэдээлэлдээ тулгуурлан өөрийгөө таньж мэдэх
- Өөрийгөө дайчлан сурч боловсрох
- Сайн суралцахын тулд өөртөө байнга хяналт тавьж үнэлгээ, дүгнэлт хийх

**Шүүн тунгаан, эргэцүүлэх чадвартай  байх…**

- Олон хувилбараар мэдээллийг олж авч түүндээ дүн шинжилгээ хийх чадвартай байх
- Асуудлыг тунгаан бодох, шийдвэр гаргах, зөрчилдөөнийг зохицуулах чадварт суралцах
- Олсон мэдлэгээ амьдралд хэрэгжүүлж сурах

**Нийгэмд идэвхтэй иргэн байх...**

- Хүрээлэн буй орчин, хамт олондоо санаа тавьж сурах
- Соёлын ялгаа бүхий хүмүүсийг хүндэтгэх, хамтран ажиллах чадварт суралцах
- Бусдын эрх ашгийг хүндэтгэдэг байх
- Өөрийн болон бусдын аюулгүй байдал, эрүүл мэндэд анхаарал тавьдаг байх

**Харилцааны өндөр чадвартай байх …**

- Мэдээллийн олон суваг ашиглаж уншиж, бичиж, сонсож, ойлгох чадварыг хөгжүүлэх, түүнийгээ дамжуулах чадвартай байх
- Техник технологийг үр дүнтэй ашигладаг байх
- Ойлгох, эргэцүүлэн бодох чадвараа сайжруулахын тулд бусдыг анхааралтай сонсож, асуулт тавьж сурах
- Хамтын зорилгодоо амжилттай хүрэхийн тулд тодорхой арга хэмжээ, төсөл дээр бусадтай хамтарч багаар ажиллаж сурах

**Насан туршдаа өөрийгөө дайчлагч, суралцагч байх …**

- Сурч боловсрох үүрэг, хариуцлагаа ойлгож ухамсарлах
- Зорилгоо тодорхойлж, дэс дараатай хөгжүүлэх, шинэчилж өөрчлөх чадвартай байх
- Өөрийгөө боловсруулах, сорих шинэ боломжийг эрэлхийлдэг байх
- Цагаа зөв төлөвлөх, хувийн зохион байгуулалтаараа өрсөлдөх чадвартай байх

## II. 2024-2025 оны хичээлийн жил

### A. Сургуулийн календарь - [Ахлах, дунд сургууль]

AMERICAN SCHOOL of ULAANBAATAR

# ASU SECONDARY SCHOOL CALENDAR 2024-2025 FOR PARENTS

| | |
|---|---|
| Aug 12 | Uniforms/Supply Sales |
| Aug 14 | 1st Semester Tuition Fee Deadline |
| Aug 14 | 1st Semester Bus Fee Deadline |
| Aug 21 | First Day of School |
| Aug 28 | 1st Semester Bus Service Begins |

**AUGUST 2024**

| S | M | T | W | T | F | S |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1 | 2 | 3 |
| 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 |
| 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 |

**FEBRUARY 2025**

| S | M | T | W | T | F | S |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1 |
| 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 |
| 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 |
| 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | |

| | |
|---|---|
| Feb 3 | 2nd Semester Begins |
| Feb 3 | 2nd Semester Bus Service Begins |
| Feb 3-14 | MAP Testing |
| Feb 19 | Coffee & Conversation |
| Feb 27 | Spirit Day |
| Feb 28 | PD Day |

| | |
|---|---|
| Sep 5 | Parent Curriculum Meeting |
| Sep 16-27 | Map Testing |
| Sep 18 | Coffee & Conversation |
| Sep 20 | PD Early Dismissal |
| Sep 23 | CCAs Begin |
| Sep 26 | Spirit Day |

**SEPTEMBER 2024**

| S | M | T | W | T | F | S |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 |
| 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 |
| 29 | 30 | | | | | |

**MARCH 2025**

| S | M | T | W | T | F | S |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1 |
| 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 |
| 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 |
| 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 |
| 30 | 31 | | | | | |

| | |
|---|---|
| Mar 3-4 | Tsagaan Sar Holiday |
| Mar 10 | CCAs Begin |
| Mar 19 | Coffee & Conversation |
| Mar 27 | Spirit Day |

| | |
|---|---|
| Oct 14-18 | Fall Break |
| Oct 25 | 1st Quarter Ends |
| Oct 28 | Report Cards Sent Home |
| Oct 31 | Spirit Day |

**OCTOBER 2024**

| S | M | T | W | T | F | S |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 |
| 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 |
| 27 | 28 | 29 | 30 | 31 | | |

**APRIL 2025**

| S | M | T | W | T | F | S |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 |
| 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 |
| 27 | 28 | 29 | 30 | | | |

| | |
|---|---|
| Apr | Seat Guarantee Fee TBD |
| Apr 4 | 3rd Quarter Ends |
| Apr 7-11 | Spring Break |
| Apr 14 | Report Cards Sent Home |
| Apr 18 | PTC |
| Apr | New Registration Begins TBD |

| | |
|---|---|
| Nov 1 | PTC |
| Nov 15 | PD Early Dismissal |
| Nov 20 | Coffee & Conversation |
| Nov 26 | Independence Day |
| Nov 28 | Spirit Day |

**NOVEMBER 2024**

| S | M | T | W | T | F | S |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1 | 2 |
| 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 |
| 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 |

**MAY 2025**

| S | M | T | W | T | F | S |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1 | 2 | 3 |
| 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 |
| 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 |

| | |
|---|---|
| May 1 | Spirit Day |
| May 5-16 | AP Exams |
| May 9 | PD Early Dismissal |
| May 17 | ASU Community Fun Day |
| May 19-30 | MAP Testing |
| May 21 | Coffee & Conversation |
| May 21 | Last Day of CCAs |
| May 29 | Spirit Day |
| May 29 | MS Spring Concert |
| May 30 | HS Spring Concert |

| | |
|---|---|
| Dec 4 | 2nd Semester Tuition Fee Deadline |
| Dec 4 | 2nd Semester Bus Fee Deadline |
| Dec 4 | Last Day of CCAs |
| Dec 11 | MS Winter Concert |
| Dec 12 | HS Winter Concert |
| Dec 16-31 | Winter Break |

**DECEMBER 2024**

| S | M | T | W | T | F | S |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 |
| 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 |
| 29 | 30 | 31 | | | | |

**JUNE 2025**

| S | M | T | W | T | F | S |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 |
| 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 |
| 29 | 30 | | | | | |

| | |
|---|---|
| Jun 2-6 | Final Exams |
| Jun 10 | MS Graduation |
| Jun 11 | Senior Graduation/Early Dismissal |
| Jun 12 | Sports Day |
| Jun 13 | Report Cards Sent Home |
| Jun 13 | Student Award Ceremony |
| Jun 13 | Last Day of Classes for Students |

| | |
|---|---|
| Jan 1-10 | Winter Break |
| Jan 13 | Classes Resume |
| Jan 27 | Report Cards Sent Home |
| Jan 31 | 1st Semester Ends |
| Jan 31 | PTC |

**JANUARY 2025**

| S | M | T | W | T | F | S |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 1 | 2 | 3 | 4 |
| 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 |
| 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 |
| 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 | |

**Notes:**
Semester 1: Aug 21, 2024 - Jan 31, 2025
Semester 2: Feb 03, 2025 - June 13, 2025

School Campus closed: July 1 - Aug 1, 2025

**Legends:**
PD - Professional Development
CCAs - Co-Curricular Activities
PTC - Parent/Teacher Conferences

**Coffee & Conversation** is an opportunity for parents to learn about ASU's different programs and practices.

www.asu.edu.mn

- Student Holidays (orange)
- Important Dates (blue)
- Public Holidays (green)

**Approved by the School Board, April 2024**

## B. Хичээлийн хуваарь

### *1. Дунд сургууль*

| Цаг | Эхлэх цаг | Төгсөх цаг | Үргэлжлэх хугацаа | Хонх |
|---|---|---|---|---|
| **Ангийн цаг** | 8:20 | 8:40 | 20 мин | Их хонх |
| **1** | 8:44 | 9:24 | 40 мин | Бага хонх |
| **2** | 9:28 | 10:08 | 40 мин | Их хонх |
| **Завсарлага** | 10:10 | 10:20 | 10 мин | Их хонх |
| **3** | 10:22 | 11:02 | 40 мин | Бага хонх |
| **4** | 11:06 | 11:46 | 40 мин | Их хонх |
| **Үдийн хоол** | 11:50 | 12:30 | 40 мин | Их хонх |
| **5** | 12:33 | 13:13 | 40 мин | Бага хонх |
| **6** | 13:17 | 13:57 | 40 мин | Их хонх |
| **7** | 14:01 | 14:41 | 40 мин | Бага хонх |
| **8** | 14:45 | 15:25 | 40 мин | Их хонх |
| **Автобус** | 15:30 | | | |

### *2. Ахлах сургууль*

| Цаг | Эхлэх цаг | Төгсөх цаг | Үргэлжлэх хугацаа | Хонх |
|---|---|---|---|---|
| **Ангийн цаг** | 8:20 | 8:40 | 20 мин | Их хонх |
| **A/E** | 8:44 | 10:08 | 84 мин | Их хонх |
| **Завсарлага** | 10:10 | 10:20 | 10 мин | Их хонх |
| **B/F** | 10:22 | 11:46 | 84 мин | Их хонх |
| **Үдийн хоол** | 11:50 | 12:30 | 40 мин | Их хонх |
| **C/G** | 12:33 | 13:57 | 84 мин | Их хонх |
| **D/H** | 14:01 | 15:25 | 84 мин | Их хонх |
| **Автобус** | 15:30 | | | |

## III. Сургалтын Бодлого

Америк дунд сургууль нь сурагч бүрт дээд зэргийн чанартай, өндөр түвшний сургалтын орчинг бүрдүүлэх зарчим баримтална. Үүний тулд бид сурагчдын сурлагыг ахиулах, сургалтын явцын талаар нарийн мэдээллээр хангах зорилго бүхий дүн үнэлгээний загварыг боловсруулж гаргасан. Үнэлгээний зарчим болон мэлээллийг сурагчдад цаг тухайд өгч үнэлгээгээ сайжруулах тал дээр тодорхой стратегийг сурагчдад цаг тухайд нь өгдөг. Эцэг эхчүүдэд сурагчийн сурлагын ахиц, амжилтын талаар тухай бүр мэдээлэл өгдөг. Гэрийн даалгавар, төсөлт ажил, дадлагын ажил, илтгэл, тест, асуулт хариулт, албан ёсны шалгалт гэх мэт шалгуураар сурагчдыг үнэлж, дүгнэнэ. Ахлах ангийн сурагчдаас жилийнтөгсгөлд хичээл бүрээс шалгалт авна.

### A. Хичээлээ шударгаар хийх

Сургууль нь сурагчийг хичээл, даалгавар хийхдээ үнэнч, шударгыг чандлан эрхэмлэж, хийж гүйцэтгэсэн даалгавар дээрээ ашигласан материал, эх сурвалжаа тодорхой бичдэг байхыг шаардана. Хичээлдээ бусдын бүтээлээс ашигласан, хуулсан, шалгалт нь дээр хуулсан сурагчдын нэрс жагсаалтад орно. Мөн хоёр дахь удаа зөрчил гарсан тохиолдолд даалгаварт тэг оноо өгөх ба хэрэв энэхүү үйлдэл дахин давтагдвал сурагчийг сургуулиас бүр мөсөн гаргах хүртэл арга хэмжээ авна. Тухайн хичээлийн багш даалгаврыг тодорхой хугацаанд дахин хийхэд зааварчилга өгөх ба (боломжтой бол өөр сэдвээр) даалгаврыг шинээр хийж гүйцэтгэнэ.

### B. Хичээлийн дүн, үнэлгээ

Сурагчийн сургалтын дүн, хичээлийн явц, ололт амжилтыг эцэг эхчүүд болон сурагчдад цаг тухайд нь илтгэж, мэдээлж байхыг бид ямагт эрхэмлэнэ. Хичээлийн жилийн явцад, нийт хоёр удаа, семестр бүрт дүн гарах бөгөөд, сурагчдын сурлага, хичээлийн явцыг эцэг эхчүүдэд зориулсан Parent Plus Portal-аас авах боломжтой. Уг сайт руу хэрхэн нэвтрэх заавaрыг Сургалтын Албанаас авна. Сурагчийн сурлагын түвшин тогтоох (MAP) шалгалтыг жилд гурван удаа авна. сурагч болон эцэг эхчүүд эдгээр тестийн дүнг ирээдүйн сурлагын төлөвлөгөөндөө ашиглах боломжтой юм.

### C. Дүн

Албан ёсны дүнгийн жагсаалт (улирал) бүрийн эцэст гарч, жилийн эцсийн ерөнхий дүнг хоёрдугаар улирлын төгсгөлд гаргадаг. Дүнгийн тайланг сурагчид болон эцэг эхчүүдэд цахим шуудангаар илгээдэг бөгөөд Эцэг эхийн Parent Plus Portal-н E-Locker-EPortfolio хэсгээс авах боломжтой.

Хичээлийн ерөнхий дүн (улирал, хагас жил, жилийн эцэс) нь УАС-ийн сургалтын стандартад нийцсэн хураангуй үнэлгээний амжилт дээр суурилдаг. Багш нар дүн тавихдаа учир утгатай, хоорондоо нийцсэн, уялдаа холбоотой арга барилыг ашиглах ёстой бөгөөд олон тооны үнэлгээний нотлох баримтаар дүнг батлах чадвартай байх ёстой.
Амжилтыг үнэлэх "хувийн-%" аргад суурилсан "Үсгийн үнэлгээ"-ийг доор үзүүлэв.

| Grade | A | A- | B+ | B | B- | C+ | C | C- | D+ | D | D- | F |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| % | 93- 100% | 90 - 92% | 87 - 89% | 83 - 86% | 80 - 82% | 77 - 79% | 73 - 76% | 70 - 72% | 67 - 69% | 63 - 66% | 60 - 62% | < 60% |
| GP | 4 | 3.7 | 3.3 | 3 | 2.7 | 2.3 | 2 | 1.7 | 1.3 | 1 | 0.7 | 0 |
| AP courses GP | 5 | 4.7 | 4.3 | 4 | 3.7 | 3.3 | 3 | 2.7 | 2.3 | 2 | 1.7 | 0 |

**D. Гэрийн даалгавар**

Үзсэн хичээлээ бататгаж, ойлгосноо шалгах, амжилтаа ахиулах, суралцах арга барил эзэмших зорилгоор сурагчдад гэрийн даалгаврыг өгнө. Эцэг эхчүүд хүүхдийнхээ даалгавраа хийж байгаа эсэхэд хяналт тавих хэрэгтэй. Хураалгасан даалгаврууд зөвхөн сурагчдын бие дааж хийсэн даалгавар байх ёстой.

**Амралтын хугацааны гэрийн даалгавар:** Сурагч хичээлд суугаагүй үеийн даалгавар нөхөх, тодорхой хугацаа заагаагүй төсөлт ажил хийх шаардлагатай үеэс бусад үед гэрийн даалгаврыг долоо хоног бүрийн амралтын өдрүүдэд болон сургуулийн урт хугацааны амралтын өдрүүдээр өгдөггүй болно. Харин ахисан түвшний хичээл (AP class) нь үүнд хамаарахгүй ба коллежийн түвшний сургалт тул нэмэлт цаг шаарддаг болно.

**Урт хугацааны чөлөө:** Зарим тохиолдолд гэр бүлийн болон бусад нөхцөл байдлаас болж сурагч удаан хугацаагаар хичээлээс завсардах үе байдаг. Ихэнхдээ багшийн ангид заасан хичээлийг болон харилцан яриа, зааварчилгааг дахин яг ижил түвшинд гэртээ давтах боломжгүй бөгөөд хамтын ажиллагааны практикыг зөвхөн сургалтын орчинд хийх боломжтой байдаг. Үр дүнтэй заах нь ойлгомжтой заах арга бөгөөд багш нар анги доторх сурагчийн ахиц дэвшлийг долоо хоногоор урьдчилан таамаглах боломжгүй тул хичээлд оролцоогүй сурагчдад гэрийн даалгаврын багцыг урьдчилан өгөх боломжгүй юм. Ангийн болон гэрийн чухал даалгавруудыг Google Classroom-ээр дамжуулан сурагчдад өгдөг./хуудас 6,7-г харна уу/

**E. Анги дэвших**

**<u>Дунд сургууль (6-8-р анги):</u>** Хоёр буюу түүнээс дээш голлох хичээл дээр (Математик, Англи хэл, Шинжлэх ухаан, Нийгэм судлал) 60%-аас доош үнэлгээ авсан сурагч анги дэвшин суралцах боломжгүй.

**<u>Ахлах сургууль (9-12-р анги):</u>** Хичээл дээр 60%-аас доош үнэлгээ авсан сурагчийн хичээлийн кредитийг өгөх боломжгүй.

Америк дунд сургуулийн ахлах ангийг амжилттай дүүргэхийн тулд сурагч 30 кредит бүхий хичээлийн кредит авсан, мөн олон нийтийн сайн дурын 40 цагийн ажилд хамрагдсан байхыг шаарддаг. Хичээлийн ирц мөн сургалтын чухал хэсэгт тооцогдоно. Хичээл дээр шалтгаантай болон шалтгаангүйгээр 15 буюу түүнээс дээш хоногоор суугаагүй бол анги дэвшин суралцах, кредитээ дүүргэхэд сөргөөр нөлөөлнө.

**F. Олон нийтийн ажил**

Америк дунд сургуулийн ахлах ангийг амжилттай төгсөхийн тулд сурагч 40 цагийн олон нийтийн ажил хийсэн байхыг шаардана. Олон нийтийн ажлыг ашгийн бус, аль нэг олон нийтийн байгууллагад хичээлийн бус цагаар гүйцэтгэнэ. Энэ ажлыг сайн дурын үндсэн дээр хувь хүн болон байгууллагад тустай нийгмийн ажлыг хийсэн байна. Олон нийтийн ажлыг гүйцэтгэхдээ сургуулиас өгсөн хүснэгтийг тухайн хувь хүн болон байгууллагад бөглүүлж хийсэн ажилдаа үнэлгээ авч баталгаажуулсан байна. Үүнийг сургалт хариуцсан захирал шалгаж баталгаажуулсан тохиолдолд 40 цагт тооцно. Шаардлагатай 40 цагийн 10-аас илүүгүй цагийг сургуулийн орчин дахь нийтийн ажилд гүйцэтгэж болно. Мөн сургууль дээр зохион байгуулагддаг бусад клуб, Сурагчдын Үндэсний Хүндэт Нийгэмлэгийн ажлууд энэхүү олон

нийтийн ажлын цагт хамаарахгүй. Олон нийтийн ажлыг гүйцэтгэх үед аливаа цалин, урамшуулал, төлбөр болон хичээлийн кредит олгохгүй.

**G. Хичээлийн дараах хөтөлбөр:**

Хичээлийн дараах хөтөлбөр нь манай сургуулийн чухал хэсэг бөгөөд сурагчдын чадварыг хөгжүүлэх төрөл бүрийн боломжийг бүрдүүлж өгдөг юм. **Сурагч бүр улирал бүр дор хаяж нэг хичээлийн дараах хөтөлбөрт хамрагдах шаардлагатай.** Энэ нь Даваа, Лхагва гарагуудын 3:30-4:20 цагийн хооронд явагддаг. Үүнд сурагчдад зориулсан онолын давтлага хичээлүүд болон ганцаарчилсан хичээлүүд багтаж болно. Мөн хөтөлбөрт хамрагдахын тулд сурагчид эцэг эхээс зөвшөөрөл авсан байна. Сурагчид зөвхөн дараах тохиолдолд CCA-с чөлөөлөгдөнө.

- Таны хүүхэд сургуулиас зөвшөөрсөн сурагчийн зөвлөлийг гишүүн.
- Таны хүүхэд улирлын чанартай (волейбол, сагсан бөмбөг, хөл бөмбөг) сургуулийн спортын багийн гишүүн.
- Таны хүүхэд сургуулиас гадуур дугуйланд хамрагддаг.

Эцэг эхчүүд хүүхдийнхээ сургуулиас гадуур дугуйланд хамрагддагийг нотлох бичгийн сургалтын албанд өгөх шаардлагатай. Үүнийг захирал эсвэл захиргааны албан тушаалтан зөвшөөрсөн байх ёстой.

**H. Valedictorian болон Salutatorian төгсөгч сонгох**

1. Сурагч тухайн сургуульд хамгийн багадаа 4 семестр сурсан байх ёстой
2. Сурагч 2 ба түүнээс дээш хичээлээс түтгэлзүүлсэн бол Valedictorian, Salutatorian байх эрхгүй.
3. Valedictorian and Salutatorian GPA тооцох аргачлал: AP хичээл сонгосон тохиолдолд 2 оноо, 1 жил хичээлээс гадуурх үйл ажиллагаанд манлайлсан бол 2 оноо, нийгмийн ажил 80 цагаас дээш хийж гүйцэтгэсэн тохиолдолд нэмэлт 10 цаг тутамд 1 оноо тооцон олгоно.
   - Жишээ 1: 3.6 GPA * 20 (үржих) + 8 (4 AP хичээл) + 1 (нийтийн ажил 94 цаг) + 4 (StuCo н/б буюу Волейболын ахлагч) = 72 + 8 + 1 + 4 + 85
   - Жишээ 2: 3.8 GPA * 20 (үржих) + 2 (1 AP хичээл) + 0 (нийтийн ажил 60 цаг) + 2 (Үндэсний хүндэт Нийгэмлэгийн нарийн бичгээр нэг жил) = 76 + 2 + 0 + 2 + 80

** Сургуулийн GPA-гийн үржүүлэгч нь 20 байна.*

## IV. Хичээлийн ирцийн бодлого

Америк дунд сургуулийн сурагчдын амжилттай суралцахын салшгүй нэг хэсэг бол сурагчийн ирц бөгөөд хичээлдээ тогтмол хамрагдах нь сурагчийн цаашдын сурах явцад шууд нөлөөлдөг гэдэгт итгэдэг. Хэрэв сурагч өвчний улмаас хичээлд суугаагүй бол эмчийн бичиг авчрах хэрэгтэй бөгөөд уг эмчийн бичиг дээр үндэслэн шалгалт/даалгаврыг нөхөн хийж болох эсэхийг шийднэ. Хичээл удаан хугацаагаар таслах нь сурлагад сөргөөр нөлөөлдөг. Олон дахин хичээлээс хоцрох нь сурагчийн сурах явцад шууд нөлөөлж байгаа бол сургуулиас хасах хүртэл арга хэмжээ авч болно. Хэрэв таны хүүхэд хичээлдээ хоцорч ирэхээр бол 08:25 минутаас өмнө сургалтын албад мэдэгдсэн байх шаардлагатай. Хичээлээс хоцрох нь сурагчийг сургуулийн зүгээс олон нийтийн ажил хийлгүүлэх эсвэл бусад үр дагаварт хүргэж болзошгүй (хичээлээс түдгэлзүүлэх гэх мэт).

**A. Хичээл таслалт**

Сурагч хичээлдээ ирэх боломжгүй тохиолдолд эцэг эх энэ талаар сургуульд хичээл эхлэхээс өмнө, Сургалтын алба руу утсаар (11-348888) эсвэл имэйлээр ss.studentservices@asu.edu.mn мэдэгдэх ёстой. Сурагч хичээлдээ эргэж ирснээ Сургалтын албанд бичгээр мэдэгдэнэ. Тухайн

сурагчийн нэр, ангийг тодорхой тусгана. Хэт их хичээл таслалт болон хоцролт нь сурагчийн анги дэвшилтэд сөрөг нөлөө үзүүлнэ.

**Урьдчилан чөлөө авах:** Сурагч урьдчилан чөлөө авах тохиолдолд эцэг эхээс шалтгааныг дурдаж, бичгээр хүсэлт гаргана. Сургалтын албанаас хичээлийн ирцийг хянах үүднээс чөлөөний хуудас бөглүүлнэ. Уг хуудсыг сурагч багш нараар бөглүүлж, хичээл дуусахаас өмнө Сургалтын албанд авчирч өгсөн байна (Чөлөөний хуудас - Хавсралт А). Зөвхөн багш нараар гарын үсэг зуруулсан хуудсанд үндэслэн сурагчид чөлөө өгөх тухай асуудлыг шийднэ. 2-оос дээш хонгоор чөлөө авах бол Сургалт Хариуцсан Захирлын зөвшөөрлийг авах ёстой.

Гэр бүлийн амралтын хугацааг сунгаж төлөвлөх нь хүүхдийн ашиг сонирхолд нийцэхгүй. Эцэг эхчүүд цахим хуудас болон сургууль дээр тавигдсан Сургуулийн хуанлийн дагуу аялалын хуваариа төлөвлөх үүрэгтэй.

**Урт хугацааны чөлөө:** Гэр бүлийн болон бусад шалтгаанаас үүдэн сурагч тодорхой хугацаагаар хичээлээс чөлөөлөгдөх үе гарна. Энэ тохиолдолд, ангид заасан хичээлүүдийг сурагч гэртээ бүрэн дүүрэн сурах боломжгүй, зааварчилгаа, дадлага зэргийг хийх боломжгүй гэдгийг ойлгох хэрэгтэй. Чөлөө авсан сурагчийн явцыг багш хянах, гэрийн даалгаврыг урьдчилан бэлтгэх боломжгүй байдаг.

Таны хүүхэд хэр удаан хугацаагаар байхгүй байхаас шалтгаанаас чөлөө олгох эсэхийг тодорхойлох ба дараах байдлаар ангилж болно:

- ☐ Зөвшөөрөгдсөн, ирцийг ЧӨЛӨӨГӨӨР тооцох ба даалгаврыг сургуулийн бодлогын дагуу зохицуулна. (жишээ нь дараах тохиолдолд: эмнэлгийн болон гэр бүлийн яаралтай тусламж, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн тэмцээн/үйл ажиллагаа)
- ☐ Зөвшөөрөгдсөн боловч ирцийг ТАСЛАЛТААР бүртгэх; сурагч даалгавар болон дүнгийн талаар багш нартай урьдчилаг мэдэгдсэнээр хамтран ажиллах боломжтой боловч энэ нь багшийн үзэмжээр шийдэгдэнэ. (жишээлбэл, гэр бүлийн амралт, аялал гэх мэт)
- ☐ Зөвшөөргөгдөөгүй, Сурагч ирээгүй тохиолдолд энэ нь ТАСЛАЛТААР тооцогдох бөгөөд бүртгэлд сөргөөр нөлөөлж, сахилгын сануулга авах (жишээ нь: урьдчилж мэдэгдэлгүйгээр гэр бүлийн амралт, уртасгасан амралт эсвэл гэнэтийн амралт гэх мэт).

Ирц бүрдүүлэх зорилгоор бүх таслалтыг бүртгэнэ. Урт хугацааны чөлөө ний хүсэлтийг сургуулийн захирал эсвэл координатаар баталгаажуулна.

Хэт их тасралтаас үүсэх үр дагавар:

- 5 удаа тасалсны дараа Сургалтын алба эцэг эхчүүдэд утсаар мэдэгдэнэ.
- 10 удаа тасалсны дараа сургуулийн захиргаа эцэг эхчүүдтэй уулзаж асуудлыг шийдэх арга замыг боловсруулах болно.
- Тогтмол таслалт: Сургуулийн захиргаа нь эцэг эхчүүдтэй холбогдож, ирцийн ач холбогдлын талаар ярилцаж, тухайн сурагчийг сургуулиас хасах эсвэл анги дэвшүүлэх боломжгүй болох магадлалыг тайлбарлаж мэдээлнэ.

**B. Засгийн газрын шийдвэрээр сургууль хаах**

Засгийн газрын шийдвэрийн дагуу сургууль хаагдах тохиолдолд сургуулийн захиргаа аль болох

хурдан эцэг эхчүүдэд имэйлээр мэдэгдэнэ. Энэ тохиолдолд сургалтын төлбөр нөхөн олгохгүй.

**C. Гэрийн багш**

Эцэг эхчүүд хүүхдийнхээ гэрийн даалгавар, хичээлд нь тус болох зорилгоор гэрийн багш авах боломжтой. Гэвч өөр улс, өөр сургуулийн сургалтын хөтөлбөрөөр биш харин манай сургуулийн хичээлийн хөтөлбөрөөр зааж чадах гэрийн багшийг олох нь чухал. Хичээлийн стандартыг хангах, амжилт гаргахад гэрийн багшийн үүрэг чухал. Эцэг эх та гэрийн багшид шаардлагатай мэдээллийг тухайн хичээл заадаг багшаас авна уу.

## V. Гар утас, цахим хэрэгсэл ашиглах

Гар утас болон бусад электрон хэрэгслүүд зөвхөн багшийн зөвшөөрөл болон хяналтан дор ашиглагдана. Хэрэв сургуулиас заасан журмаас гадуур гар утас болон бусад элетрон хэрэгслүүдийг ашиглавал хурааж авах болно. Шалгалтын үеэр чихэвч зүүхийг хориглоно.

## VI. Дүрэмт хувцасны журам

Сурагчдын хувцаслалтын дүрэм нь манай сургуулийн соёлын чухал хэсэг юм. Иймээс дүрэмт хувцасны журмыг хичээлийн жилийн турш мөрдөнө. Сурагчдын дүрэмт хувцсыг Даваа- Пүрэв гарагуудад өмсөх журамтай. Баасан гарагт энгийн хувцаслаж болно. Сурагчдыг үсээ содон өнгөөр будах, мөн сургууль дээр малгай өмсөхийг хориглоно.

**Дүрэмт хувцас нь:**
- Сургуулийн лого бүхий цахилгаантай гадуур малгайтай цамц
- Сургуулийн лого бүхий урт болон богино ханцуйтай поло цамц
- Хөвгүүд сургуулийн лого бүхий хар хөх өнгийн өмд, харин охид сургуулийн лого бүхий хар хөх өнгийн өмд болон сургуулийн лого бүхий хар хөх өнгийн юбка, хар өнгийн трико/ретузны хамт өмсөнө. Өвлийн саруудад (11-р сараас 3-р сар) охид хар өнгийн трико/ретузны гадуур дулаан хар өнгийн ноосон урт оймс өмсөнө.
- Онцгой тохиолдолд багаар эсвэл ангиараа захиалан өмсөх малгайтай цамц/гадуур цамц зэргийг өмсөх үед дотуур нь заавал дүрэмт хувцас өмсөнө.

**Юбка:**
- Мэргэжлийн энгийн хувцаслалтын нормыг дагаж мөрдөх ёстой;
- Урт нь сурагчийн гарын уртаас (хурууны үзүүр) богино байх ёсгүй бөгөөд сургуулиас тогтоосон урттай (өвдөгний дээд хэсгээс 8 см-с ихгүй) байна.

**Гутал**
- **Зураас гаргадаггүй** гутал өмсөнө;
- **Спортын гутал тохиромжтой. Хар эсвэл цагаан өнгийн байх шаардлагатай ба өөр өнгө орсон бол мөн хар болон цагаан өнгө** (өөр өнгөнүүд маш бага хэмжээгээр байж болно) байна.
- **Ботинк (түрийтэй гутал) нь хар эсвэл цагаан өнгийн байх шаардлагатай ба өөр өнгө орсон бол мөн хар болон цагаан өнгө** (өөр өнгөнүүд маш бага хэмжээгээр байж болно) байна.
- Гутал дээр тод өнгөтэй, металл тоног зэрэг элдэв чимэглэлгүй байх.

**Нүүр будалт, үс:**
- Нүүр будалт энгийн, үсний өнгө/засалт энгийн байна. Хэтрүүлсэн, нүдэнд өртөхүйц, бусдын анхаарлыг татсан будалт, үсний өнгө/засалтыг зөвшөөрөхгүй.

**A. Хөвгүүдийн дүрэмт хувцас**

| | | | |
|---|---|---|---|
|  |  |  |   |
|  Зураас гаргадаггүй |  Зураас гаргадаггүй |  Зураас гаргадаггүй |  Зураас гаргадаггүй |

**B. Охидын дүрэмт хувцас**

| | | | |
|---|---|---|---|
|  |  |  |   |
|  Зураас гаргадаггүй |  Зураас гаргадаггүй |  Зураас гаргадаггүй |  Зураас гаргадаггүй |

**Дүрэмт хувцасны дүрмийг зөрчсөн тохиолдолд:**

- Эцэг эхүүдийг дуудах болон солих хувцас авчруулна.
- Сурагчид тэр өдрийн хичээлд суухгүй ба хичээлээс түдгэлзүүлэх болно.
- Удаа дараалан дүрэм зөрчсөн тохиолдолд гэрт нь буцаана эсвэл багадаа нэг өдөр сургууль дотор хичээлээс түр түдгэлзүүлэх арга хэмжээ авна.

Шаардлагад нийцсэн хувцас өмсүүлэх нь эцэг эхийн үүрэг юм.

Баасан гарагт энгийн хувцаслаж болно. Хэрэв сурагчийн энгийн хувцаслалт нь зүй зохисгүйд тооцогдох аваас гэр лүү нь буцаана. Дүрэмт хувцас болон хувцаслалтын дүрэмтэй холбоотой асуулт, тодруулах зүйл байвал Сургалтын Албанд хандана уу.

**Чөлөөт хувцастай өдрөөр өмсөх хориотой хувцас:**

- Урагдсан хувцас
- Хүзүүний шугамаас өвдөг хүртэлх ямар нэгэн арьсыг ил гаргасан хувцас (жич: хэт богино цамц)
- Богино юбка, богино цамц, хэт бариу цамц, майк
- Садар самууныг сурталчилсан эсвэл сэтгэл түгшээсэн агуулгатай бичигтэй хувцас

**Биеийн тамир, эрүүл мэндийн хичээлийн хувцаслалт:** Сурагчид сургуулиас зөвшөөрөгдсөн биеийн тамирын хувцсыг өмсөнө. Хичээлийн өмнө болон дараа хувцас солих өрөөг ашиглана. Бусад үед хувцас солих өрөөнд хувцас үлдээж болохгүй. Биеийн тамирын хувцас нь:

- Биеийн тамирын өмд нь доогуураа резинтэй байна. Богино өмд нь зөвшөөрөгдсөн зохих хэмжээний урттай байна.
- Цамцыг өмдний дотуур хийх
- Хар зураас гаргадаггүй спорт гутал өмсөх, зузаан ултай эсвэл уулын гутал өмсөхгүй байх
- Урт үстэй бол үсээ боосон байх, ямар нэг гоёл чимэглэлгүй байх

**Танилцах аялал болон сургуулиас зохион байгуулж буй арга хэмжээний үеэрх хувцаслалт:** Сурагчид аялал эсвэл сургуулиас зохион байгуулж буй бүх арга хэмжээ (Жишээлбэл: Нээлттэй хаалганы өдөрлөг, концерт гэх мэт)-нд зохих хувцаслалтын дүрмийг дагаж мөрдөх ёстой. Мөн УАС шууд зохион байгуулдаггүй ч ивээн тэтгэдэг, сурагчид оролцдог аливаа арга хэмжээ (жишээ нь спорт)-ний хувцаслалт орно. УАС-ийн сурагчийн хувцаслалтын дүрмийг дагаж мөрдөөгүй сурагчийг аливаа арга хэмжээний үеэр сургуулийн албан хаагчдын аль нэг нь шууд гэрт нь хариулж болно.

## Сургуулийн дүрэмт хувцас болон дүрэмд нийцээгүй хувцас өмссөн зөрчил удаа дараа гаргасан сурагчийг гэрт нь буцаана.

УАС-ийн дүрэмт хувцас болон хувцаслалтын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг Сургалтын албанаас авч болно.

**C. Сурагчийн үнэмлэх**

Бүх сурагчид сурагчийн үнэмлэхийг байнга биедээ зүүж явах бөгөөд үнэмлэхгүй ирсэн сурагчдыг гэр лүү буцаах эсвэл 3,000 төгрөг төлж, шинээр авахыг шаардана. Сурагчийн үнэмлэх нь сургуулийн дүрэмт хувцасны нэг хэсэг болно. Сурагчийн үнэмлэх зүүх нь сургуулийн аюулгүй байдалд хамаатай бөгөөд сурагчын дүрэмт хувцасны нэг хэсэг болно.

## VII. Өдрийн хоолны төлбөр

Сурагч бүрийн үнэмлэхэд хоолны төлбөрт зориулсан төлбөр тооцооны данс байршуулсан бөгөөд эцэг эхчүүд, доод тал нь долоо хоногоор хүүхдийнхээ дансыг урьдчилан цэнэглэх үүрэгтэй. Хоолны газарт үнэмлэхээр тооцоо хийх сурагчид очер дарааллын давуу эрхийг эдлэнэ. Харин бэлэн мөнгөөр тооцоо хийх сурагчид очер дарааллын сүүлд байна.

## VIII. Яаралтай үед холбоо барих

Сургуулиас хүүхдийн эцэг эх болон бусад хүмүүстэй холбогдохдоо хэдийгээр хичээлийн цаг байлаа ч холбоо барих боломжтой. Тиймээс эцэг эхүүд яаралтай холбоо барих утасны дугаарыг сургуульд өгсөн байх ёстой. Холбоо барих дугаар өөрчлөгдсөн тохиолдолд сургуульд мэдэгдсэн байна.

## IX. Сурагчийн шүүгээ

6-12-р ангийн хүүхэд бүр эд зүйлс, номоо хадгалах сурагчийн шүүгээ ашиглана. Их хэмжээний мөнгө, үнэтэй эд зүйлсийг сургуульд авчирч шүүгээнд хийхийг хориглоно. Шүүгээнүүд нь сургуулийн өмч бөгөөд сурагчдын хэрэгцээнд зориулагдсан байна.

2024-2025 оны хичээлийн жилд: Сурагчид шүүгээндээ хэрэглэх өөрийн цоож авчрах ба онгойлгох кодыг сургалтын албанд өгнө. Тохиромжтой цоожийг сургуулийн мөн ресепшнээс худалдаж авах боломжтой. Цоож нь шүүгээнд таарч, хэвийн ажиллагаатай байх нь эцэг эх, сурагчдын үүрэг юм.

Сургуулийн захиргаа шүүгээг хэдийд ч нээх эрхтэй. Хэрэв шүүгээний код ажиллахгүй эсвэл сургуульд онгойлгох кодыг өгөөгүй бол шаардлагатай тохиолдолд сургууль цоожыг таслах эрхтэй. Тус тохиолдолд сурагч болон эцэг эх шинэ цоож худалдан авах зардлыг хариуцна.

Сурагчид цоожныхоо кодыг бусадтай хуваалцах ёсгүй. Мөн гадуур хувцас, гутлыг сурагчийн шүүгээнд хадгалах ёстой. Шүүгээг буруугаар ашиглавал шүүгээний засвар, солих зардлыг сурагч болон эцэг эх гарах болно. Сурагчид өөрсдийн өмч хөрөнгөө хариуцна. Шүүгээний дээгүүр эд зүйлсийг байрлуулахыг хориглоно, ийм тохиолдолд сургуулийн Хаясан Гээсэн Зүйлс хэсэгрүү шилжүүлэх болно.

**Сурагчийн шүүгээ болон кодтой цоож ашиглах дүрэм**

- Сургуулиас бүх сурагчдад зориулсан хувийг болон сургуулийг эд зүйс хадгалах зориулалтын шүүгээгээр хангана.
- Хичээлийн жилийн эхэнд сурагчид шүүгэнд хэрэглэх өөрийн цоож авчирах ба онгойлгох кодыг сургалтын албанд өгнө.
- Хичээлийн жилийн төгсгөлд сурагчид шүүгээг хоослон онгорхой үлдээнэ.

Сурагч коридорт, ангид эсвэл шүүгээний дээр зэрэг шүүгээнээсээ гадуур эд зүйлсээ орхисон тохиолдолд сургуулийн Хаясан Гээсэн Зүйлс хэсэгрүү шилжүүлэх болно.

## X. Хаясан гээсэн зүйлс

Сургуулийн байрны эргэн тойронд олдсон бүх зүйлийг сургуулийн үүдний танхимд байрлах “Хаясан Гээсэн” хайрцагт хийнэ. Эзэн нь олдоогүй тохилдолд улирал бүрийн эцэст улсын 60-р сургууль, Veloo Foundation Буяны санд хандивлана**.**

## XI. Эцэг эх сургуулийн хамтын ажиллагаа

### A. Эцэг эхийн зүгээс санал хүсэлт гаргах

Америк дунд сургууль нь харилцан нээлттэй байх харилцааг эрхэмлэнэ. Эцэг эхийн санал хүсэлтийг дараах байдлаар хүлээн авна:

1. Эхлээд хүүхдийнхээ багштай цаг товлон уулзах.
2. Хэрэв сэтгэл хангалуун бус бол Сургалт хариуцсан захиралтай эсвэл дунд сургуулийн координатортой цаг товлон уулзах.
3. Дээрх уулзалтаас гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй тохиолдолд Үйл ажиллагаа хариуцсан захиралтай цаг товлон уулзах. (Уг уулзалт нь алба ёсны шийдвэр гаргах үйл явцын нэг хэсэг ба Үйл ажиллагаа хариуцсан захирал эцэслэн шийдвэрлэнэ.)

### B. Сурагчийн зүгээс санал хүсэлт гаргах

Асуудлыг аль болох бага түвшинд шийдвэрлэх зорилгоор сугагчийн санал хүсэлтийг дараах байдлаар хүлээн авна:

1. Эхлээд багштай ярилцана.
2. Хэрэв сэтгэл хангалуун бус байвал дунд сургуулийн сурагч нь дунд сургуулийн координатортой, ахлах сургуулийн сурагч нь Ахлах сургуулийн Зөвлөх багштай ярилцана.

### C. Эцэг эхийн уулзалт, санал хүсэлт

Америк дунд сургуулийн бүх эцэг эхчүүдийг сургуулийн хичээлийн хөтөлбөр, бодлогын талаар мэдээлэл авах, асуулт асуух зорилгоор сар бүрийн Кофетой яриа уулзалтанд оролцохыг дэмждэг. Мөн сургуулийн санал асуулганд оролцон санал хүсэлтээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.

### D. Эцэг эхийн сайн дурын оролцоо

Бид эцэг эхийн сайн дурын оролцоог үргэлж таатай хүлээн авч ажилна. Сургуулийн хамт олонд өөрийн мэдлэг туршлагаа хуваалцах, анги танхим болон аливаа арга хэмжээнд туслах зэрэг олон сонголт бий. Мөн эцэг эхчүүдийг олон сурагчид хамааралтай, хичээлийн холбогдолтой өөрийн салбарын туршлага мэдлэгээс хуваалцахыг уриалж ажилна. (зочин лекц гэх мэт).

## XII. Хориотой зүйлс

Сургууль дээр болон сургуулиас зохиогдож буй арга хэмжээний үеэр тамхи, согтууруулах ундаа, мансууруулах бодис, өөрт болон бусдад аюул учруулж болзошгүй бусад зүйлсийг (зэвсэг, зэвсэг болгож ашиглаж болох зүйл) биедээ авч явах, хэрэглэх, худалдахыг хориглоно. Урьдчилан

сэргийлэх үүднээс сургууль сурагчийн цүнх, шүүгээнд үзлэг хийх эрхтэй. Мөн бусад сурагч, ажилчдын хувийн зөвшөөрөлгүйгээр зургийг нь авах, бичлэг хийхийг хориглоно.

Электрон дугуй SURON зэрэг сургуулийн байранд унаж ирэх болон зогсоолд байршуулах хориотой. Сурагч нь жолооны үнэмлэхгүйгээр сургуулийн байранд ямар нэгэн моторт техник хэрэгсэл унаж ирэх хориотой. Зөвхөн сургуулийн захиргаанаас хүлээн зөвшөөрөн, зогсоолын үнэмлэх олгосон сурагчид зогсоолд унаагаа байршуулах эрхтэй.

**Сургуулийн байранд жолоо барин ирэх сурагчдын дүрэм**

1. Хэрэв насанд хүрсэн ахлах ангийн сурагч сургууль дээр автомашин, мотоцикл жолоодон ирэх бол жолооны үнэмлэхийн хуулбар, эцэг эхийн зөвшөөрлийг урьдчилан сургуулийн захиргаанд өгнө.
2. Сургуулийн захиргаа бичиг баримтыг шалгаж үзсэний дараа тухайн сурагчид автомашин мотоцикл жолоодон сургуулийн байранд ирэх зөвшөөрөл болох “Driver Pass” тэмдэг олгоно. Энэ зөвшөөрлийг машины цонхон дээр илээр байрлуулж харуулд үзүүлэн сургуулийн хашаанд орно.
3. Харуулийн алба энэ зааврыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Хэрэв тухайн сурагч энэ заавартыг мөрдөөгүй тохиолдолд тухайн автомашин болон мотоциклийг сургуулийн хашаарuu оруулахгүй болно.
4. Хэрэв сурагч өөрийнхээ машинаа сольж гэр бүлийн гишүүн болон өөр хэн нэгний автомашин, мотоциклийг унаж ирэх бол сургуулиас олгосон зөвшөөрөлийг үзүүлж сургуулийн хашаарuu орно.
5. Сурагч автомашин болон мотоцикл унаж ирэхдээ замын хөдөлгөөний дүрэм журамтай холбогдол бүхий асуудал, автомашины аюулгүй байдал, хамгаалалтын малгай, бүс зүүх гэх мэт хувь хүний хариуцлагатай хамааралтай асуудлыг зөвхөн сурагч өөрөө хариуцана.
6. Ажлын өдрүүд буюу Даваагаас -Баасан гаригуудад “Driver Pass” авсан сурагч автомашин буюу мотоциклоо сургуулийн төв зогсоол дээр байрлуулж хичээлдээ орно. Сурагч тусгайлан зөвшөөрөл аваагүй тохиолдолд сургуулийн арын талбайд багшийн байрны ойролцоо машинаа тавихыг хориглоно. Хичээл тарсанаас хойш автомашины зогсоол, замын ачаалал багассан, сурагчдын автобус хөдөлсөнөөс хойш 5-10 минутын дараа автомашин, мотоциклоо унаж сургуулийн хашаанаас гарна.

## XIII. Сургуулийн автобус үйлчилгээний журам

Америк дунд сургуулийн сурагчдад автобусны төлбөртэй үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэй, мэргэжлийн байгуулага сонгож хамтарч ажиллана. Автобусанд чанга яригч, нууц дуран суурилуулсан бөгөөд сургуулийн захираанаас баталсан энэхүү журмыг мөрдөж ажиллана.

******Тайлбар: Америк дунд сургууль автобусны үйлчилгээг тогтсон байршил дээрээ тогтсон цагаасаа 1-3 минутын өмнө гарч ирж чадах хүүхдэд үйлчилнэ******

**A. Сургуулийн үүрэг**

1. Автобусанд хянагч байхгүй тул камер чанга яригч суурилуулсан автобусаар үйлчилнэ. Харин эцэг эхтэй холбоо барих гар утсыг жолооч нарт хангах үүргийг сургуулийн захиргаа хариуцаж эцэг эхийн гар утсыг жолоочид өгнө.
2. Эцэг эх автобусны маршруттай танилцсны дараа, энэ үйлчилгээг авах гэрээг байгуулна. Автобусны үйлчилгээ эхлэхээс 2 долоо хоногийн өмнө гэрээ байгуулах ажлыг хийнэ. Гэрээ байгуулж, төлбөр төлснөөр тухайн сурагчийн автобусны суудал баталгаажна. Үүний дараа сурагчдын нэрсийг жолоочид хүргүүлнэ.
3. Хэрэв тухайн маршрутанд суудал дүүрсэн тохиолдолд дараагийн автобусыг нэмж захиалж болно. Ингэхдээ автобусны суудлын дүүргэлт 70 хувь болсон тохиолдолд шинээр автобус захиалах ажлыг сургуулийн захиргаа хийнэ.
4. Автобусны жолоочид тавьж байгаа тусгай шаардлагыг эцэг эхэд танилцуулнна. Эцэг эх, жолоочийн хооронд гарсан маргааныг шийдвэрлэхэд сургуулийн захиргаа туслалцаа үзүүлнэ. Хэрэв шаардлагатай гэж үзвэл автобусны жолооч нарт хүүхэдтэй харьцах наад захын сургалт зохион байгуулахад туслана.
5. Сургуулийн захиргаанаас автобусны жолоочид тавьж буй шаардлагын биелэлтийг хянах гэнэтийн шалгалтыг сард 1 удаа хийнэ. Хяналтаар илэрсэн дутагдлыг арилгах санаачлагыг автобусны компанитай хамтарч шийдвэрлэнэ.
6. Автобусны үйлчилгээний үндсэн маршрутыг өөрчлөх, шинэ хүүхдийг, шинэ хорооллоос авах зэрэг асуудлыг сургуулийн захиргаатай хамтарч шийдвэрлэнэ. Ингэхдээ зөвхөн асфальтан болон бетон хучилттай, баталгаатай замаар хүүхэд тээвэрлэх бодлогыг тууштай баримтална.
7. Автобусанд суух хүүхдийн насны доод хязгаар нь 6 нас (1-р ангийн сурагч) байна. Харин, заасан хязгаараас доош насны хүүхдийг нэг гэр бүлийн ах эгч нар нь харгалзаж явахыг эцэг эх албан бичгээр зөвшөөрсөн тохиолдолд үйлчилгээнд хамруулж болно.
8. Энэхүү автобусны үйлчилгээний журмын 3.1, 3.2, 3.4 болон 3.5-р заалтуудыг зөрчсөн сурагчдын автобусны үйлчилгээ авах эрхийн асуудлыг сургуулийн захиргаа хэлэлцэх үүрэгтэй. Хэрэв дээрх заалтуудыг удаа дараалан зөрчсөн тохиолдолд сургуулийн захиргаа өөрийн санаачлагаар автобусны гэрээг хүчингүй болгох эрхтэй.
9. Автобусны жолооч нарт зориулан сургуулийн захиргаанаас хүүхдийн аюулгүй байдал , харилцааны талаар сургалт орно.
10. Автобусны техникийн гэмтэл, жолоочийн буруутай үйлдлийн улмаас үйлчилгээ үзүүлэх боломжгүй болвол хүүхэд тээвэрлэх үйлчилгээ үзүүлж чадаагүйн хохирлыг автобусны компанид тавьж, барагдуулах ажлыг сургууль хариуцна.

**B. Эцэг эхийн үүрэг**

1. Эцэг эхчүүд хүүхэддээ автобусан дотор биеэ зөв авч явах зааварчилгааг өгсөн байна.
2. Маршрутанд заасан зогсоол дээр хүүхдээ 5 минутын өмнө ирүүлсэн байх үүрэгтэй.
3. Бага насны хүүхдийг зогсоол дээр хүргэж өгөх, тосож авах ажлыг эцэг эх хариуцна. Хэрэв энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд, жолооч тухайн хүүхдийг сургууль дээр буцаан авчирна. Эцэг эх хүүхдээ сургуулийн харуул дээрээс ирж авна.
4. Хэрэв хүүхэд өвдсөн болон бусад шалтгаанаар автобусанд суухгүй тохиолдолд эцэг эхчүүд өмнөх өдөр эсвэл өглөө эрт жолоочид мэдэгдэх ёстой.

5. Сурагч товлосон цагт, товлосон зогсоол дээр гарч ирээгүйн улмаас автобусанд сууж чадаагүй тохиолдолд эцэг эхчүүд хүүхдээ өөрсдөө сургуульд хүргэж өгнө. Энэ тохиолдолд автобусны үйлчилгээний төлбөрийг нөхөн олгохгүй.
6. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас автобус цагаасаа 15 минутаар хоцорсон тохиолдолд эцэг эх хүүхдээ сургуульд хүргэж өгөх үүрэгтэй. /Хальтаргаа, гулгаа, цас мөс, салхи шуурга, усан мөндөр зэрэг замын хөдөлгөөнд харшлах нөхцлүүдийг давагдашгүй хүчин зүйлд тооцно./ Энэ тохиолдолд төлбөрийн буцаалт олгохгүй.
7. Хэрэв нэгэнт байгуулсан автобусны гэрээг цуцалвал эцэг эх сургуулийн захиргаанд албан ёсоор бичгээр мэдэгдэнэ. Энэ тохиолдолд төлбөрийн буцаалтыг батлагдсан журмын дагуу шийдвэрлэнэ.

**C. Сурагчийн үүрэг**

1. Сурагч автобус хөдлөхөөс өмнө суудлаа эзэлж, аюулгүйн бүсийг зүүсэн байна. Автобус зогсоол дээр бүрэн зогссоны дараа сурагч суух/буух үйлдлийг хийнэ.
2. Сурагч өглөө автобусны зогсоол дээр 5 минутын өмнө ирсэн байна. Орой хичээл тарсны дараа автобусанд 5 минутын дотор багтаан суусан байна.
3. Сурагч зөвхөн сургууль дээр буух, гэртээ харих тогтсон маршрутаар, заасан зогсоол дээр буух. Сурагч өөр хүсэлт жолоочид тавих эрхгүй. Сурагч автобуснаас буугаад зам хөндлөн гардаг бол автобусны араас 3 метрийн зай барьж гарцаар гарна.
4. Сурагчид хоорондоо нам дуугаар ярилцаж, зөв боловсон үг яриа хэрэглэнэ. Сурагч биеэ зөв зохистой авч явж, бусадтай хүндэтгэлтэй харьцана. Хэрэв хэн нэгэнтэй хүндэтгэлгүй харьцсан бол уучлалт гуйх үүрэгтэй.
5. Автобусанд болсон аливаа маргаан, зохисгүй үйлдлийг хоёр тал зөвөөр шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд шаардлагатай үед автобусны камерийн бичлэг дээр үндэслэн шийдвэрлэнэ.
6. Сурагч автобусанд юм идэх, уух, хувцас солих, амьтан авч явах, шовх, хурц иртэй, хагарамтгай зүйлсийг биедээ авч явах, мөн автобусны үйлчилгээ аваагүй найз нөхдөө дагуулж явахыг хориглоно.

**D. Жолоочийн үүрэг**

1. Жолооч автобусанд суурилуулсан чанга яригч болон камерийг байнгын ажиллагаатай байлгана. Хүүхдийн гар, толгой цонхоор чөлөөтэй гарахгүй, хурц нар нүүрэн дээр тусахгүй байх хамгаалалтыг автобусандаа хийсэн байна.
2. Автобусны суудлын бүрээс, суудлын дэр, шал, цонх, бариул, хана, хаалга тааз зэрэг эд ангийг бүрэн бүтэн бөгөөд, цэвэрхэн байлгах үүрэгтэй. Жолооч өөрөө хувийн ариун цэвэр сахисан байна. Өвлийн улиралд автобусыг дулаан байлгах ба автобусан дотор утаа, угаар гаргахгүй.
3. Жолооч сурагчидтай зөв зохистой харьцана. Сурагчдыг буух/суух, зогсоол дөхөж байгааг чанга яригчаар мэдэгдэх, мөн унтсан хүүхдийг сэрээж зогсоолд нь буулгах үүрэгтэй. Хэрэв сурагч цагтаа зогсоол дээрээ ирээгүйн улмаас автобусанд суугаагүй бол эцэг эхэд нь мэдэгдэнэ.
4. Жолооч сургуулиас өгсөн хүүхдийн нэрсээр, тогтоосон маршрутаар, тогтсон цагт хүүхдийг буулгах үүрэгтэй. Жолооч хүүхдийн болон эцэг эхийн хүсэлтээр маршрутаас хазайх, байр орцны үүднээс очиж авах/буулгахыг хориглоно.
5. Автобусны үйлчилгээний асуудлаар тавьж буй эцэг эхийн санал хүсэлтийг жолооч сургуулийн захиргаанд уламжлах үүрэгтэй. Харин дур мэдэн шийдвэр гаргахыг хориглоно.

6. Хэрэв сургуулийн захиргаанаас жолоочид ажлаа сайжруулах үүрэг өгсөн бол тодорхой хугацаа өгч, хамтран ажиллана.
7. Хэрэв жолоочтой холбоотой асуудлаар эцэг эхээс гомдол / санал ирвэл сургуулийн захиргаа жолоочийг байлцуулан хамтарч, шийдлийг олно. Жолооч энэ үед уян хатан, тэвчээртэй хандахыг эрхэм болгоно.
8. Жолооч ажлын байранд архи тамхи үнэртүүлэх, ёс бус үг хэллэг хэрэглэх, эцэг эхтэй зохисгүй харьцах, бусдын хэрэгт хөндлөнгөөс оролцох, өөрт хамааралгүй асуудалд ач холбогдол өгөх, дур мэдэн маршрут солих, цагаа барихгүй хүүхэд эцэг эхэд төвөг удах, бусдын эрх ашгийг үл хүндэтгэх, автобусанд хоол идэх, найз нөхдөө автобусандаа суулгаж дагуулж явах, хүлээлтийн цаг ашиглаж тамхи татах, эрсдэлтэй жолоочийн болон замын хөдөлгөөний үйлдэл хийхийг хориглоно.

## XIV. Хичээлийн хэрэгсэл, сурах бичиг

### A. Ном сурах бичиг

Сурагчдыг сургуулиас сурах бичгээр хангана. Сурах бичиг нь сургуулийн өмч бөгөөд цэвэрхэн хэрэглээд жилийн эцэст сургуульд буцаан өгнө. Номыг гадна хавтасыг харагдах, тунгалаг хавтсаар хавтаслана. Эцэг эх сурагчийн номын барьцаа болох 750.000₮ (Дунд анги) 1000.000₮ ( Ахлах анги) төлнө. Сурагч өөр сургуульд шилжих тохиолдолд номоо бүрэн хүлээлгэн өгсний дараа номын барьцаа мөнгөө бүтнээр буцаан авах ба хэрэв номоо хаяж гээгдүүлсэн тохиолдолд номын барьцааны төлбөрөөс суутгаж авна. Номын барьцаа төлөгдөөгүй тохиолдолд төлбөрөөс автоматаар хасаж суутгана.

### B. Бусад хэрэглэл

Эцэг эх, сурагчид зарим тохиолдолд аль нэг хичээлд шаардлагатай нэмэлт хичээлийн хэрэглэлийг худалдаж авах шаардлага гарах ба эдгээр нэмэлт хичээлийн хэрэглэлийг сургуулийн үүдний хэсгээс худалданавах боломжтой. Эдгээр нэмэлт хэрэглэлд хөгжмийн хичээлийн дэвтэр, хятад хэлний ханзны дэвтэр, гар урлалын хичээлийн хэрэглэл, тооны машин гэх зэрэг орно.

**<u>Тооны машин:</u>** Сурагч асуулт хариулт, шалгалтын үеэр ухаалаг гар утсыг тооны машин хэлбэрээр ашиглах хориотой. Сурагч өөрийн тооны машин авчрах ШААРДЛАГАТАЙ ба шалгалтын үер өөрийн тооны машинаа бусадтай хуваалцах хориотой.

Энгийн тооны машиныг дурын бичиг хэргийн дэлгүүр болон сургуулийн үүднээс худалдан авах боломжтой.

Анги, хичээл бүрийн шаардлагатай тооны машины төрлүүдийг доор байрлуулав.

| | | | |
|---|---|---|---|
| **6-8 дугаар анги** | Энгийн язгуур квадрат функц бүхий тооны машин. | Энгийн үйлдэлтэй тооны машин<br> | |
| **9-10 дугаар анги (Алгебр I, Геометр, Алгебр II, Физик , Хими)** | Хаалт болон тригонометрийн функц бүхий стандарт олон үйлдэл бүхий тооны машин . | Олон үйлдэл бүхий тооны машин<br> | “Олон үйлдэлт” тооны машин ахлах сургуульд хэрэг болох ба зургийг харна уу. |
| **11-12 дугаар анги (Статистик, Прэ-калкулус, Математик Аппликашн, Ахисан түвшний Калкулус, болон бусад математикийн хичээлүүд)** | График тооны машин. | График тооны машин: TI 84 Plus CE<br> | График тооны машин 11-12 дугаар ангидаа математик болон физикээр сурах төлөвлөгөөтэй сурагчдад зөвлөж байна.<br><br>Зөвлөж буй загвар: TI-84 Plus CE (Python) мөн бусад TI-84 загварын байж болох ба TI-84 загвар биш бол шаардлагагүй.<br><br>Сургуулийн бичиг хэрэгт график тооны машин зарагддаг. (зөвхөн агуулахад байгаа тохиолдолд) |

## XV. Сургуулиас зохиох аялал

**Зорилго:** Сургуулиас гадуур туршлага судлах аялал (сурагчдын аялал) нь срагчдын суралцах чадварыг сайжруулах, хичээлийн агуулгын "бодит ертөнц"-ийн хэрэглээг мэдрэх үр дүнтэй арга юм. Сургуулиас зохион байгуулах бүх аялал нь боловсролын шинж чанартай бөгөөд УАС-ийн сургалтын хөтөлбөрийн чухал хэсгийн нэг юм.

**Зардал:** Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт жилд 2 удаа аялалын зардал (даатгал, түлш, зогсоол, автобусны жолоочийн цалин) -ийг Улаанбаатар дахь Америк сургууль хариуцдаг. Эцэг эх нь үдийн хоол болон хотоос гадуурх аялалын зардлыг хариуцаж, боломжтой бол бүх аялалд сурагчдыг оролцуулах үүрэгтэй. Сурагчид аялалд сургуулиас олгосон тээврийн хэрэгслээр ирж, буцах ёстой, эс тэгвээс зөвшөөрлийн хуудас хүчингүй болно. Аялалын зардлыг эцэг эхчүүд хариуцна.

**Тээвэр:** Сурагчид сургуулиас олгосон тээврийн хэрэгслээр аялалд явах болон буцах ёстой.

**Эцэг эхийн зөвшөөрөл:** Эцэг эхчүүд хичээлийн жилийн эхэнд сурагчдын аялалд оролцох зөвшөөрлийн хуудас (Хавсралт А) бөглөнө. Мөн, аялал бүр нь тус тусын нэмэлт зөвшөөрлийн хуудас дахин шаардаж болно.

**Хээрийн аялалын удирдамж:** Багш нар зарим тохиолдолд эцэг эхчүүдийг сурагчдын аялалд ахлагчаар оролцож, туслахыг хүсдэг.

- Хээрийн аялалд олон тооны хүүхдүүд оролцдог тул эцэг эхчүүд "Хэрэв хүүхэд ийм зүйл хийвэл яах вэ?" гэж үргэлж бодож хүндэтгэлтэй, хариуцлагатай, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.
- Эцэг эх асран хамгаалагчдын хяналт сурагчдын зөв зохистой аялахад их тустай байдаг. Хэрэв насанд хүрэгчид шаардлагатай үед аялалыг хянах ажлыг хуваалцдаг бол сурагчдын аялал нь илүү тааламжтай байх болно.
- Хэрэв сурагч нь эцэг эхийн хүсэлтэд хариу үйлдэл өгөхгүй, сонсохгүй бол эцэг эх нь багшид мэдэгдэх үүрэгтэй.
- Эцэг эх асран хамгаалагчид ихэвчлэн өөрийн хүүхдийн эргэн тойронд байдаг. Илүү үр дүнтэй байхын тулд эцэг эх сайн дурынхан зөвхөн өөрийнхөө хүүхдийг биш бүх сурагчдыг хянаж, тэдэнд туслалцвал зохистой.
- Сурагчдын аялалд 12 сурагч тутамд 1-ээс доошгүй насанд хүрсэн хүн хяналт тавьж явах ёстой.

**Хоногоор явах аялалын удирдамж:** Хоногийн аялалд багш нар болон бусад асран хамгаалагчид дараах зүйлсийг дагаж мөрдөхийг шаарддаг.

- Аялал жуулчлалын аль ч үед согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис, электрон тамхи болон бусад хориотой эд зүйлсийг авч явахыг хориглоно.
- Багш, асран хамгаалагчид сурагчидтай нэг өрөөнд/гэрт хонохгүй.
- Багш, асран хамгаалагчид шөнийн цагаар сурагчдын аюулгүй байдлыг хангах үүднээс байнгын хяналт шалгалт явуулна.

## XVI. Сурагчийн ёс зүйг хянах хөтөлбөр (CICO Check-in Check-Out)

### A. Хөтөлбөрийн тодорхойлолт

Уг хөтөлбөр нь 6-8 дугаар ангийн сурагчдад зориулсан хөтөлбөр бөгөөд зорилго нь сурагч өдөр бүр бүх хичээл дээр гурван сонгосон ёс зүйг баримталж зорилго болгон суралцах юм. Хөтөлбөрт хамрагдсан сурагч бүр хянагчтай (багш ажилчид болон сайн дурын хянагч) байх ба тухайн сурагчид урам өгч туслах юм.

### B. Сурагчийн зүгээс

Хөтөлбөрт хамрагдсан сурагч өдөр бүр хичээл эхлэхээс өмнө Дунд сургуулийн координатораас CICO хуудсаа авч (Хавсралт B) тухайн өдрийн хичээлд оролцоход бэлэн эсэхээ шалгана. Ингэснээр сурагч урамшиж өөрийн зан авираас ичих, сөрөг хандлага зэргээс зайлсхийх юм.
Өдрийн турш сурагч хичээл заасан багш бүрээс хичээлд хэрхэн оролцсон талаар үнэлгээ авч CICO хуудас дээрээ тэмдэглүүлнэ. (1-3 оноо)

Хичээлийн төгсгөлд Дунд сургуулийн координаторт CICO хуудсаа хураалгаж шалгуулна.

Хөтөлбөрт хамрагдах хугацаанд дээрх байдлаар өдөр бүр давтагдна.

**C. Багшийн зүгээс**

Багш хөтөлбөрт орох шаардлагатай гэж үзсэн сурагчийг Дунд сургуулийн координатор болон Сургалт хариуцсан захиралд танилцуулна.

Сурагч доорх тохиолдолд хөтөлбөрт хамрагдана:

- 2-6 долоо хоногийн турш муу (60-с доош) дүнтэй суралцсан бол.
- Багшаас 3 удаа сахилга батын хуудас авсан бол.
- 30 хоногийн хугацаанд 5 удаа хичээл тасалсан бол.
- Бусдад болон өөрт аюултай зан авир гаргасан бол.
- Ямар нэгэн сэтгэл зүйн асуудал байгаа бол.
- Гэр бүлийн зүгээс нэмэлт тусламж хүссэн бол.

Сурагч бүрийн хөтөлбөрт хамрагдах хугацаа харилцан адилгүй ба дараах тохиолдолд дуусгаж болно:

- ➢ Өдөр бүрийн үнэлгээнд суурилсан дундаж оноог харгалзан дор хаяж 4 долоо хоног тасралтгүй зорилгоо биелүүлсэн үед. Дор хаяж 4 долоо хоногийн турш хичээлийн 5 өдрийн 4-т зорилгоо биелүүлсэн үед.
- ➢ Сахилга батын хуудас авалгүй дор хаяж 4 долоо хоног болсон үед хөтөлбөрийг дуусгаж болох сайн үзүүлэлт гэж үзнэ.

**Эцэг эх асран хамгаалагч нарт өгөх зөвлөмж**

- Таны хүүхэд зорилгоо биелүүлсэн буюу өндөр оноо авсан өдөр нь үнэлж байх.
- Таны хүүхэд зорилгоо биелүүлж чадаагүй өдөр нь шийтгэхгүй байх. Тэдэнд дараагийн өдрийн боломж байгаа.
- Боломжтой бол сайн байсан өдөр нь ямар нэг зүйлээр шагнаж байх.

**D. Нийгэм, сэтгэл зүйн зөвлөх**

Тус зөвлөх нь Бага болон Ахлах Дунд сургуулийн байранд ажилладаг ба зөвлөхтэй ярилцах хүсэлт гаргасан сурагч нэг удаагийн уулзалт хийх боломжийг олгоно. Харин сурагч эсвэл зөвлөх нь дараагийн уулзалтыг хийх хүсэлт гаргавал сургалтын албаар дамжуулан эцэг эхчүүдтэй холбогдоно.

**E. Сургуулийн сувилагч**

- Сувилагч нь сургуулийн кампус дээр өглөөний 08 цагаас өдрийн 4 цаг 30 минут хүртэл байрлан ажиллана. Бүх ажилчид эмнэлгийн тусламж шаардлагатай сурагчдийн эцэг эх рүү залгаж мэдэгдэхийн өмнө сувилагчид шалгуулна. Сувилагч сурагчийн биеийн байдлыг үзэж шалгасны дараа сургалтын албанд эцэг эхийг дуудаж ямар зөвлөгөө заавар өгөхийг хэлнэ. Толгойн бөөсний сэжигтэй тохиолдолд сувилагч сурагч болон ойрын хүмүүст үзлэг хийнэ. Үзлэг, эмчилгээтэй холбоотой зөвлөмжийг эцэг эхчүүд дагах үүрэгтэй.

## XVII. Сурагч төвтэй сургалтын орчин

Америк дунд Сургууль нь ирээдүйн удирдагчдыг бэлтгэн гаргах зорилготой бөгөөд “Сур, Амжилт гарга, Манлайл” гэсэн уриан дор ажилладаг.

Бидний эрмэлзлэл :

- Хүүхдийн ашиг сонирхлыг дээдэлсэн сургалтын орчинг бүрдүүлэх
- Сургууль дээр халуун дулаан уур амьсгал бүрдүүлэх
- Сурагч бүрийн сурах арга барилыг хүндэтгэх
- Хүүхдийн асуудал шийдвэрлэх, сонголтоо зөв хийх, бүтээлч байх мөн өөрийгөө илэрхийлэх зэрэг чадварыг хөгжүүлэх
- Хүүхдийг ааш зан, оюуны болон нийгэмшлийн хувьд төлөвшүүлэх үүднээс эерэг дүр төрхийг бүрдүүлэх
- Эцэг эх, сургуулийн хамт олон, сурагчдад хүндэтгэлтэй хандах
- Өөрийн хийсэн үйлдлийн үр дагаврыг ухамсарлаж, хийсэн үйлдэлдээ хариуцлага хүлээж чаддаг болгож сургах
- Онол дадлага хосолсон сургалтын хөтөлбөрөөр хангах

**A. Сурагчийн ёс зүйн хэм хэмжээ**

Сурагчийн сайн сахилга бат нь сургуулийн эрхэм зорилго, алсын хараа, ESSO-ийн сурагчийн эзэмших чадваруудыг биелүүлэх орчныг бүрдүүлж өгдөг.

**<u>Сурагчид дараах журмыг мөрдөнө:</u>**

- Бусдын болон өөрийн эрх, өмч, аюулгүй байдалд хүндэтгэлтэй хандана.
- Соёлтой үг хэллэг хэрэглэх, ёс зүйтэй байдлаар өөрийгөө илэрхийлнэ.
- Бусдыг тохуурхах, доромжлох, хүч хэрэглэх, ялгаварлан гадуурхах хэлбэрээс ангид байна.
- Сургуулийн дүрэмт хувцас, хувцаслах журмыг сахина.
- Хичээл, дугуйлан, арга хэмжээнд идэвхтэй оролцох, цаг барьж, бэлтгэлтэй оролцоно.
- Сургууль дээр бусдын эрхэнд хүндэтгэлтэй хандана.
- Сургуулийн болон бусдын эд хөрөнгөнд хүндэтгэлтэй хандана.
- Дэг журамтай, эерэг, аюулгүй сурах орчинг бүрдүүлэх хэмжээнд биеэ авч явна.
- Сургуулийн байранд үнсэлцэх, тэврэлдэх, хөтлөлцөх, гэх мэт дотно харилцааг ил гаргасан үйлдэл гаргахгүй байх. /Хавсралт И харна уу/

**<u>Дараахи тохиолдолд сурагчийг хичээлээс түр түтгэлзүүлнэ:</u>**

- Бусдын биед ноцтой гэмтэл учруулахаар үйлдэл хийсэн бол;
- Шалгалт/ тестийн үеэр хуулах, хуурах үйлдэл гаргасан бол;
- Зөвшөөрөлгүйгээр сургуулиас гарч явсан бол;
- Сургуулийн эд хөрөнгийг эвдэн сүйтгэсэн бол;
- Багш болон дээд тушаалын хүнтэй бүдүүлэг үг хэллэг, хараал хэрэглэсэн бол;
- Хулгай дээрэм хийсэн бол;
- Бусдын биед зүй бусаар хүрсэн, зодоон хийсэн бол;
- Согтууруулах ундаа, тамхи, электрон тамхи зэрэг хориотой зүйлс хэрэглэх болон биедээ авч явсан, хадгалсан бол;
- Зэвсэг болон хууль бус зүйл хэрэглэх болон биедээ авч явсан, хадгалсан бол;
- Шууд болон шууд бусаар бусдыг дарамтлах, айлган сүрдүүлэх, заналхийлэх болон гэмтээсэн бол;
- Бусдын сэтгэл зүйн байдалд хор хөнөөл учруулах, гэмтээх оролдлого хийсэн бол;

- Сургуулийн нэр хүндэд халдсан үйлдэл гаргасан бол; (үүнд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл багтна-Хавсралт D);
- Багш болон сургуулийн ажилчдыг үл тоомсорлох, бүдүүлэг, үл хүндэтгэсэн зан байдал гаргасан бол;
- Зохисгүй, хор хөнөөлтэй материал (зураг, видео, текст гэх мэт) ямар ч хэлбэрээр (дижитал болон биет гэх мэт) эзэмших, түгээсэн бол;
- Эдгээр зөрчлийн аль нэгийг нь өөгшүүлэх, өдөөн турхирч, мэдээлэхгүй байсан бол.

Эдгээр шалтгааны улмаас хичээлээс түр түтгэлзүүлсэн сурагчийг эцэг эхтэй нь уулзаж ярилцсаны дараа хичээлд буцаан суух зөвшөөрөл өгнө. Сурагчийг хичээлээс түр түдгэлзүүлсэн үед сурагч сургуулийн байранд орох, сургуультай холбоотой сургуулийн байранд болон сургуулиас гадуур зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд оролцохыг хориглоно.

**B. Сурагчийг сургуулиас хасах**

Тухайн сурагчийг сургах нь сурагч болон сургуулийн аль алины эрх ашигт нийцэхгүй байгаа тохиолдолд сурагчийг сургуулиас хасах эрхтэй. Тухайлбал, сурагчийн хүмүүжил бусад сурагчдын аюулгүй байдал, нэр төрд сөргөөр нөлөөлж байгаа, сургуулийн ёс зүй, үнэт зүйлд харшилж буй бол, сургуулиас шаардаж буй хичээлийн ирц, сурлагын наад захын шаардлагыг хангахгүй бол, эсвэл сурагчийг суралцах хугацаанд **3 удаа хичээлээс түдгэлзүүлсэн** тохиолдолд сургуулиас хасна.

**C. Сургуулийн бүртгэлээс (автоматаар) хасах журам**

Доорх шалтгааны улмаас сурагчийг сургуулийн бүртгэлээс автоматаар хасах шийдвэр сургуулийн захиргаанаас гаргах болно.

- Сурагч 30 ба түүнээс дээш таслалттай бол.
- Сургалтын төлбөр болон бусад төлбөрийг цаг хугацаанд нь барагдуулаагүй тохиолдолд.
- Сурагч нь 12 дугаар анги төгсөх шаардлагуудыг амжилттай биелүүлээгүй бол.
- Эцэг эх/асран хамгаалагч нь сургуультай 3 ба түүнээс дээш сарын хугацаанд холбоогүй байсан бол.
- Эцэг эх/асран хамгаалагч сургуулиас тавьсан асуудалд 3 ба түүнээс их харилцаанд хариу өгөөгүй бол.
- Эцэг эх/асран хамгаалагч одоо хэрэглэж буй холбоо барих мэдээллээ сургуульд өгөөгүй бол
- Эцэг эх/асран хамгаалагч нь эцэг эх багш нарын хуралд 2 улирал буюу 1 семестр оролцоогүй бол
- Эцэг эх/асран хамгаалагч нь сургалт хариуцсан  захирал эсвэл үйл ажиллагаа хариуцсан захирлын зүгээс шаардсан уулзалтанд 2 ба түүнээс дээш удаа ирээгүй бол.
- Эцэг эх/асран хамгаалагч нь тухайн сурагчид албан ёсны асран хамгаалагч олголгүйгээр 45 ба түүнээс дээш хоног Монголоос явсан тохиолдолд.

## XVIII. Сургалтын албаны ажилтан ба ахлах сургуулийн зөвлөх

**A. Сургалтын албаны ажилтнууд**

Сурагчийн эцэг эхтэй уулзалтын цаг тохирох, шаардлагатай үед орчуулга хийнэ. Тэд сурагчийн элсэлтийн бүртгэл, дүнгийн хуулга, сургуулийн бүртгэлээс хасалт хийх зэргийг хөтлөн явуулдаг.

**B. Ахлах сургуулийн зөвлөх багш**

Ахлах сургуулийн зөвлөх нь элсэлтийн шалгалтыг зохицуулж, сурагчдийг сонгон шалгаруулалт, коллежийн бэлтгэлд удирдан чиглүүлдэг.

**C. Сургуулиас гарах хүсэлт**

Хэрэв сурагч нь сургуулиас гарах/шилжих хүсэлтэй бол тухайн сурагчийн эцэг эх нь сургалтын албанд бичгээр хүсэлт гаргана. Уг хүсэлтийг хүлээн авсны дараа сурагч нь тойрох хуудсаа бөглүүлэн сургуулийн ном сурах бичгээ буцааж, санхүүгийн алба зохих төлбөрийг эцэг эхэд буцаан олгоно.

**D. Төгсөгчдын гээгдсэн дипломыг нөхөн олгох хүсэлт**

Хэрэв Америк дунд сургуулийг төгссөн төгсөгчид дипломоо гээгдүүлсэн, хулгайд алдсан, гэмтээсэн, тохиолдолд ахлах сургуулийн зөвлөх багшид (counselor@asu.edu.mn) хаяглаж диплом нөхөж авах хүсэлт гаргана. Диплом нөхөж олгох төлбөр нь 500,000 төгрөг байх бөгөөд захиалга өгснөөс хойш 4-6 долоо хоногийн дотор багтаан гаргаж өгнө.

Нөхөн олгох дипломыг тухайн жилд ажиллаж буй Сургалт хариуцсан Захирал, ТУЗ-ын дарга нар хариуцан гаргаж өгнө. Нөхөн олгох дипломын төлбөрийг санхүүгийн албанд төлсөнөөр захиалга баталгаажих ба ахлах сургуулийн зөвлөх багшаас хүсэлт хүлээн авсан и-майл очих болно.

**E. Дүнгийн хуулга, дагалдах материал**

Ахлах сургуулийн 9-12-р ангийн сурагчидын дүнгийн хуулга түүний баталгаажуулах ажлыг Сургалтын алба, Сургалтын зөвлөх багш нар хариуцна. Хичээлийн жилийн турш сурагчид 3 удаа дүнгийн хуулга буюу түүний дагалдах материалыг үнэ төлбөргүй хүлээн авна. Харин энэхүү материалыг 3-с дээш хувь авах тохиолдолд хүсэлт гаргасан өдрөөс хойш ажлын 3 хоног (яаралтай тохиолдолд)-т, ажлын 5 хоногт (ердийн тохиолдолд)-т нэмэлт хувийг гаргаж өгнө. Яаралтай тохиолдолд 1% багц материал 10000₮, ердийн тохиолдолд 5000₮ байна. Энэхүү нэмэлт үйлчилгээ нэг буюу түүнээс өмнө жилүүдэд төгссөн сурагчид хамаарна.

## XIX. Технологи, Интернет хэрэглээ

Сургуулийн компьютерийг зөвхөн хичээлийн зорилгоор ашиглана. Сурагч номын сан болон IT лабораторийн компьютер дээр зөвшөөрөлгүйгээр программ суулгах болон устгахыг хориглоно.

## XX. Хавсралт - Маягт болон бодлогууд

**ХАВСРАЛТ А: Сургуулиас чөлөө авах маягт – Ахлах дунд сургууль**

**ЧӨЛӨӨ АВАХ ХУУДАС – 3 ХОНОГ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ**

**ЗӨВШӨӨРӨГДСӨН ТОХИОЛДОЛД ИРЦ "ЧӨЛӨӨ" -Р ТООЦОГДОНО. ГЭСЭН ХЭДИЙ Ч СУРАГЧИД ХИЧЭЭЛДЭЭ БУЦАЖ ИРЭНГҮҮТ ЭСВЭЛ БАГШИЙН ЗӨВШӨӨРСНИЙ ДАГУУ БҮХ ОРХИГДСОН ДААЛГАВРАА ӨГӨХ ҮҮРЭГТЭЙ.**

**ОРХИГДСОН ХИЧЭЭЛ, ДААЛГАВРЫН ТАЛААР БАГШ НАРТАЙГАА ХОЛБООТОЙ БАЙХ НЬ СУРАГЧИЙН ҮҮРЭГ БОЛНО**

Сурагчийн нэр: _________________________ анги: __________________

Чөлөө авах өдөр______________________ хүртэл:____________________

Шалтгаан:

| |
|---|
| |

**Аль нэгийг сонго нуу**

- ☐ **Эрүүл мэндийн шалтгаанаар**
- ☐ **Гэр бүлийн яаралтай шалтгаанаар**
- ☐ **Аялал/Амралт**
- ☐ **Бусад яаралтай шалтгаан**

Эцэг эх, асран хамгаалагчийн гарын үсэг:_________________

Сурагчын гарын үсэг:__________________

---

**СУРГУУЛИЙН ЗАХИРГААНЫ АЖИЛТАН**:

- ☐ Зөвшөөрөгдсөн, ирцийг **ЧӨЛӨӨГӨӨР** тооцох ба хичээл, даалгаврыг сургуулийн бодлогын дагуу зохицуулна.
- ☐ Зөвшөөрөгдсөн болович ирцийг **ТАСЛАЛТААР** бүртгэх; сурагч даалгавар болон дүнгийн талаар багш нартай урьдчилан мэдэгдсэнээр хамтран ажиллах боломжтой болович энэ нь багшийн шийдвэрээр хэрэгжинэ.
- ☐ Зөвшөөргөгдөөгүй, Сурагч ирээгүй тохиолдолд энэ нь **ТАСЛАЛТААР** тооцогдох бөгөөд бүртгэлд сөргөөр нөлөөлж, сахилгын сануулга авна.

ЗАХИРАЛ/КООРДИНАТ__________________________ Огноо: __________

## ХАВСРАЛТ Б: Маргаан шийдвэрлэх журам

Манай сургууль аливаа асуудал, бэрхшээлийг үр дүнтэй, ухаалгаар шийдвэрлэх чадварыг сурагчдадаа суулгах зорилготой ажилладаг. Эцэг эх, сурган хүмүүжүүлэгч бид аливаа асуудалыг шийдвэрлэх тал дээр хүүхдүүддээ сайн үлгэр дууриал үзүүлж байх ёстой. Бид ямар ч үед аливаа гомдол, асуудалд боломжит шийдлийг аль болох эрт гаргахыг зорьдог. Гэсэн хэдий ч, зарим тохиолдолд аливаа маргаанд оролцогч талуудын мэдлээс хэтрэх тохиолдол бий. Сургуулийн багш, ажилтан, сурагч, эцэг эхийн хоорондох харилцан ойлголцлыг сайжруулах, бие биенээ хүндэтгэн харилцах, сургуулийн орчинд эерэг уур амьсгалыг бий болгохыг чухалчлаж энэхүү маргаан шийдвэрлэх журмыг гаргасан болно.

1. **Маргаан шийдвэрлэх албан бус үе шат**

1.1. Аливаа асуудлыг шийдвэрлэх эхний алхам нь оролцогч талууд өөрсдийгөө бүрэн ойлгуулж, асуудлаа хоорондоо хэлэлцэн, ярилцаж, шийдвэрлэхийг оролдох нь маш чухал. Асуудлыг сургуулийн удирдлагын түвшинд шийдвэрлүүлэхээсээ өмнө оролцогч талууд бие биенийхээ хүслийг бүрэн ойлгосон эсэхээ дахин нягтална. (жишээ нь, багш тухайн эцэг эх, хамтран ажиллагчийнхаа юу хүсээд/асуугаад байгааг бүрэн ойлгосон уу? эсвэл эцэг эх-багшийг) Эцэг эх, багш нар тухайн асуудлын мөн чанарыг тодорхойлохын тулд өөрт ойлгомжгүй байгаа зүйлсээ асуух хэрэгтэй. Маргаан ялангуяа удирдлагын түвшинд хүрсэн бол маргаанд оролцогч талууд өөрсдийн байр сууриа тодорхой илэрхийлэхэд бэлтгэлтэй байх нь зүйтэй. Мөн оролцогч талуудын аль аль нь хүлээн зөвшөөрөх тэрхүү шийдлийг гаргаж ирсэн байх ёстой.

1.2. Хэрвээ асуудал доод түвшинд шийдвэрлэгдэж чадахгүй тохиолдолд ажилтнууд Сургалт Хариуцсан Захиралтай зөвлөлдөж уг асуудлыг ярилцах уулзалтыг товлоно. Бүх талын дуу хоолойг сонсож, бүрэн ойлголт авахын тулд маргаанд оролцогч бүх талууд уулзалтанд оролцоно.

1.3. Хэрвээ асуудлыг албан бус үе шатаар хангалттай шийдвэрлэж чадаагүй бол гомдол гаргагч этгээд нь асуудал шийдвэрлэх албан ёсны үе шатыг дагаж мөрдөнө.

2. **Маргаан шийдвэрлэх албан ёсны үе шат**

2.1. Гомдол гаргагч ажилтан, албан хаагч нь сургуультай хамаатай асуудлыг удирдлагын түвшинд шийдвэрлүүлэх хүсэлтэй бол гомдолтой, асуудалтай байгаа нөхцөл байдлаа тайлбарлаж, дэлгэрэнгүй баримтаар нотолсон албан ёсны өргөдөлийг Сургалт Хариуцсан Захиралд өгнө.

2.2. Сургалт Хариуцсан Захирал асуудал шийдвэрлүүлэх хүсэлт буюу гомдол гаргасан бичгийг хүлээн авч асуудлыг судласаны дараа ажлын 3 хоногт багтаан хариуг бичгээр өгнө. Гомдол гаргагч нь Сургалт Хариуцсан Захирлын шийдвэр буюу үйлдэлийг зөвшөөрсөн эс зөвшөөрсөн ч хариу захидал хүлээн авсанаа мэдэгдэж, гарын үсэг, огноо зурж өгнө.

2.3. Хэрвээ гомдол гаргагч Сургалт Хариуцсан Захирлын шийдвэрлэсэн үйлдлийг хүлээн зөвшөөрч байвал гомдол гаргагчийн гарын үсэг зурсан бичгийн хувийг хадгалж үлдэнэ.

2.4. Хэрвээ гомдол гаргагч Сургалт Хариуцсан Захирлын хийх үйлдлийг хүлээн зөвшөөрөхгүй байвал тухайн асуудалтай холбогдол бүхий мэдээллийг багтаасан хавтасыг Сургуулийн Ерөнхий Захиралд шилжүүлэн өгнө.

2. 5 Ийнхүү Ерөнхий Захирал тухайн асуудалтай холбогдол бүхий мэдээллийг судлаж, явцын дунд гарч ирсэн өөр шинэ мэдээлэл байвал харгалзан үзэж, эцсийн шийдвэрийг гаргана

## ХАВСРАЛТ В: Сурагчийн ёс зүйг хянах хөтөлбөрийн (CICO) Хуудас

AMERICAN SCHOOL of ULAANBAATAR
Learn * Achieve * Lead

### Check-in/Check-out Sheet

Student Name: ______________ CICO Mentor: ________________ Date: ____________

3=used skill consistently; 2=used skill 1 to 2 times; 1=Did not use skill

**Classroom Expectations** (Highlight behavior goals for student in each area.)

| Organization | Attitude | Responsibility | Respectful | Communication | Effort |
|---|---|---|---|---|---|
| *Prepared for class with materials<br>*Takes notes for homework and/or unfinished classwork<br>*Manages time well | *Has a positive attitude<br>*Helpful to others<br>*Uses kind language with others | *Uses active listening<br>*Completes work on time<br>*Stays on task | *Follows class directions<br>*Responds to adults and peers respectfully<br>*Stays in assigned seat and /or area | *Communicates effectively with teachers and peers<br>*Active participation in group and class discussion | *Consistently puts effort into work<br>*Self-motivated<br>*Does personal best |

**Morning Check In:**

My goal today is: ________________

**Afternoon Check Out (check one):**

_____ I met my goal today _____ I had a tough day

One thing I did really well today was: ___________________________

Something I will work on tomorrow is: ___________________________

AMERICAN SCHOOL of ULAANBAATAR
Learn * Achieve * Lead

| Goals →<br>Period ↓ | Organization | Responsibility | Effort | Class Total | Teacher Initials and Comment |
|---|---|---|---|---|---|
| Homeroom | 1 2 3 | 1 2 3 | 1 2 3 | | |
| Period 1 | 1 2 3 | 1 2 3 | 1 2 3 | | |
| Period 2 | 1 2 3 | 1 2 3 | 1 2 3 | | |
| Period 3 | 1 2 3 | 1 2 3 | 1 2 3 | | |
| Period 4 | 1 2 3 | 1 2 3 | 1 2 3 | | |
| Period 5 | 1 2 3 | 1 2 3 | 1 2 3 | | |
| Period 6 | 1 2 3 | 1 2 3 | 1 2 3 | | |
| Period 7 | 1 2 3 | 1 2 3 | 1 2 3 | | |
| Period 8 | 1 2 3 | 1 2 3 | 1 2 3 | | |
| Total | | | | /81 | % of Points _____<br>Goal Met (80% or above) ______ |

**Parent Signature and Feedback:** ____________________________

## ХАВСРАЛТ Г: Олон нийгмийн сүлжээ ашиглах удирдамж (Сошиал Медиа)

Сургуулийн ажилтан, албан хаагчид, багш, сурагч болон эцэг эхчүүд нийгмийн сүлжээ болон интернет аппликейшнийг ашиглахдаа энэхүү удирдамжийг баримтална.

Америк сургууль нь 21-р зуунд суралцах нь харилцаа холбоо маркетинг болон бусадтай харилцах арга барил өөрчлөгдөж буйг хүлээн зөвшөөрдөг. Шинэ технологийг ашиглан түүндээ багш, сурагч, эцэг эхийг татан оролцуулж хамтран суралцах нь сургалтыг сайжруулж илүү үр дүнтэй болгодог. Энэ зорилгын үүднээс Америк дунд сургуулийн медиа бодлого нь багш ажилчдыг төрөл бүрийн онлайн арга хэмжээнд идэвхитэй оролцохыг, сурагчдын амжилтыг тэмдэглэсэн мөчүүдийг зургуудаар дамжуулан олон нийтийн сүлжээнд оруулахыг уриалдаг ба сургуулиас зохион байгуулж буй арга хэмжээг зурагжуулан сургуулийн олон нийтийн сүлжээнд байршуулдаг.

Гэхдээ, хувь хүний хийсэн үйлдэл сургуулийн нэр хүндтэй шууд хамааралтай тул хариуцлагатай байх нь ихээхэн чухал. Сургуулийн олон нийтийн сүлжээнд зураг, мэдээ нийтлэхийн тулд эхлээд сургуулийн захиргаа руу тайлбарын хамт илгээн шалгуулдаг.

### Сурагчдын аюулгүй байдлыг хангахтай холбоотой сургуулийн ажилчдын нийгмийн сүлжээ ашиглалтын бодлого

Нийгмийн сүлжээнд хувийн болон албаны харилцаа холбоо алдагдах нь их байдаг тул Америк сургуулийн ажилчид, багш нар интернетийн орчинд мэргэжлийн ёс зүйг баримталж байх ёстой. Түүнчлэн, нийгмийн сүлжээгээр ёс бус авир гаргахгүй байхыг санах үүрэгтэй.

Америк дунд сургууль нь олон нийтэд хүртээмжтэй мэдээлэл цацах үүднээс нийгмийн сүлжээг ашигладаг. Ингэснээр манай сургуулийн талаарх мэдээллийг бусад хүмүүс олон нийтэд хуваалцах боломжийг нээж өгдөг. Сургуулийн Фэйсбүүк хуудсанд нэгдсэн хүмүүс манай сургуулийн талаарх мэдээллийг байнга авах боломжтой. Тиймээс бусад оролцогч талууд, шинээр элсэн сурах сурагчид, эцэг эхчүүд, төр иргэний байгууллагын харилцаа холбоо үүсгэх боломжийг нээж өгдөг.

Сургалт хариуцсан захирал, Үйл ажиллагаа хариуцсан менежерийн зөвшөөрөлгүйгээр сургуулийн логог ямар нэгэн зорилгоор ашиглахыг ажилчдад хориглоно. Сурагчдынхаа аюулгүй байдлыг хангах үүднээс, Сургуулийн ажилчид нийгмийн сүлжээг ашиглахдаа дараах зүйлсийг байнга санаж байх үүрэгтэй:

- ✔ **Бусад хүмүүсийг автоматаар тэмдэглэхгүй байх**: (таны нийтэлсэн зураг, мэдээлэлд бусад хүмүүсийг автоматаар таниулж, тэмдэглэх).
- ✔ **Газар зүйн байршлыг тэмдэглэхгүй байх**: (нийтэлж буй мэдээлэлд газар зүйн байршлыг тэмдэглэх. Энэ нь тухайн байршлыг өргөрөг, уртраг, газарзүйн байршлын нэр, зай, өндөрлөг зэрэг мэдээллийг агуулдаг)
- ✔ **Овог хэрэглэхгүй байх**: (зөвхөн өөрийн нэрийг, овгийн эхний үсэгтэй бичих).
- ✔ **Нууцлалыг байнга хадгалах**: Гэр бүлээр авхуулсан зураг болон бичлэгийг хэзээч олон нийтийн сүлжээгээр цацахгүй байх. Сургуулийн өмч, эсвэл нууцлалтай холбоотой аливаа мэдээллийг сургуулийн ажилчид нийтлэхгүй байна.
- ✔ **Ил тод байх**: Сурагчид болон тэдний гэр бүлтэй ойр дотно харилцаа үүсгэсэн, тухайн сурагчийн гэр бүл, найз нөхөд, хамтран ажиллагсдын хувьд та сургуулийг төлөөлж байгаа гэдгээ байнга санах.

✔ **Эцэг эхэд мэдээлэх**: Сурагчдыг нийгмийн сүлжээ, аппликэйшн ашиглах төсөлд оролцож байгаа мэдээллийг багш нар эцэг эхэд урьдчилан мэдээлэх хэрэгтэй.

**Интернет нийтлэл, нийгмийн сүлжээнд оролцох сургуулийн ажилтны хувь хүний хариуцлага**

- ➢ Багш, сурагчдын онлайнаар харилцах бүх төрлийн харилцаа зөвхөн хичээл, сургууль, эсвэл сургуультай холбоотой бусад арга хэмжээтэй холбоотой байна.
- ➢ Нийгмийн сүлжээ ашигладаг сургуулийн ажилчид сурагчдын хувийн нууцлалтай холбоотой ямар нэгэн мэдээлэл, зургийг зөвшөөрөлгүйгээр ашиглах, нийтлэхийг хориглоно.
- ➢ Сургуулийн хамт олны овгийн нэр, хаяг, имэйл хаяг, утасны дугаар зэргийг олон нийтийн сүлжээнд нийтлэхийг хориглоно.
- ➢ Бусадтай нүүр харан харилцаж байгаатай нэгэн адил онлайнаар ёсзүйтэй, хүндлэлтэй, үнэнч шударга хадаж харилцана.

**Эцэг эхчүүдийн нийгмийн сүлжээнд сургуулийн хамт олны оролцоо**

Сурагчдын дундах онлайн харилцаа, бусад нийгмийн сүлжээний хэрэглээ нь сурагчид, эцэг эх, багш нар өөр хоорондоо харилцах үүсэх хүчирхэг хэрэгсэл юм. Ийм харилцаа холбоо нь сурах боломжийг нээж өгдөг сайн талтай. Тиймээс эцэг эхчүүд нийгмийн сүлжээгээр дамжуулан сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, зөв зохистой саналаа оруулах боломжтой.

**Нийгмийн сүлжээг ашиглахдаа Сургуулийн эцэг эхчүүд дараах журмыг мөрдлөгө болгоно**

- ☑ Хүүхдийнхээ зураг болон бичлэгийг олон нийтийн сүлжээнд байршуулахыг хүсэхгүй тохиолдолд, хичээлийн жилийн эхэнд *Зураг бичлэг нийтлэх зөвшөөрлийн хуудасыг* уншин танилцах. /ХАВСРАЛТ Д/
- ☑ Онлайн хичээлийн мэдээллийг эцэг эхчүүд хууль бусаар, буруугаар ашиглахыг хориглоно
- ☑ Нийгмийн сүлжээн дэх төсөлийн ажлын мэдээллийг эцэг эхчүүд байнга уншиж, шаардлагатай үед оролцох ёстой
- ☑ Сургуулийн бусад сурагчдын хувийн мэдээллийг эцэг эхчүүд бусдад түгээх, нийтлэхийг хатуу хориглоно
- ☑ Онлайн хичээлтэй холбоотой, төслийн ажлуудын талаар эцэг эхчүүд хамгийн түрүүнд тухайн хичээлийн багштай холбоо барих.

## ХАВСРАЛТ Д: Гэрэл зураг, видео бичлэг ашиглах зөвшөөрөл

### Сургуулийн вэбсайт ба олон нийтийн харилцаанд ашиглагдах зураг, видео бичлэг

Бид сурагчдынхаа аюулгүй байдал, хувийн мэдээллийг хамгаалах үүднээс сургуулийн вэбсайт дээр тавих мэдээллийг хатуу журмаар цохицуулдаг. Олон нийтийн үйл ажиллагаанд хамрагдах тусгай тохиолдолд сурагчдын зураг болон видео бичлэгийг ашиглах тохиолдол гардаг. Мөн сонин сэтгүүл, сургуулийн сурталчилгаа болон гарын авлага зэрэгт ашиглах мэдээллийг нийтийн хэвлэлд гаргадаг. Хүүхдийн аюулгүй байдал нэн тэргүүнд тавигдах учраас нийтлэгдэхээс өмнө мэдээллийн агуулгыг багш, ажилчид сайтар хянадаг. Олон нийтийн хэвлэлд гарч байгаа зураг, бичлэг дээр шаардлагатай гэж үзсэн тохиолдолд сурагчдын нэрийг овоггүйгээр нь ашигладаг. Сургуулийн зүгээс хүүхдийн овог нэрийг ямар ч тохиолдолд бүтнээр нь олон нийтэд түгээж хэвлэхгүй.

____________________________би дээрх нөхцөлийг уншиж танилцсан ба энэ хичээлийн жилд миний хүүхдийн зураг, бичлэгийг ямар нэгэн зорилгоор ашиглахгүй байхыг Улаанбаатар Америк сургуулиас хүсэж байна.

Сурагчийн нэр: _____________________ __________Анги:__________

Эцэг эх/асран хамгаалагчын гарын үсэг: __________________________

Он сар өдөр: _______________

## ХАВСРАЛТ Е: Хүүхэд Хамгааллын бодлого

Сургууль нь сурагчдынхаа эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хангах ёс суртахууны болон хууль ёсны үүрэгтэй байдаг билээ. Америк дунд сургуулийн Хүүхэд хамгааллын бодлого нь хүүхдийн эсрэг ямарваа нэгэн хүчирхийлэл гарах эрсдэлийг бууруулах, ямарваа нэгэн хүчирхийллийн шинж тэмдэг ажиглагдах, сэжиг гарах, илрэх тохиодолд сургуулийн ажилтан, багш, сурагчид, сайн дурын ажилтнууд болон зочид хэрхэн үр дүнтэй, шуурхай хариу үйлдэл үзүүлэхийг заасан журам юм. Энэхүү иж бүрэн бодлого нь доорхи бүрэлдэхүүн хэсгээс хамаарна.

Америк дунд сургууль нь хүүхэд хамгааллын талаарх Монгол Улсын болон олон улсын хууль тогтоомж, дүрэм журам, хэм хэмжээг бүрэн дагаж мөрддөг. Америк дунд сургуулийн багш, ажилчид доор заасан арга хэмжээнүүдээс гадна сурагчдийн хооронд үүссэн нөхөрсөг бус харилцаа, маргаан, зөрчлийг эвлэрүүлэх, зохицуулах, ар гэрийнхэнд нь мэдэгдэх зэргээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

Уг бодлого нь Хүүхэд хамгааллын дараах чухал  хэсгүүдийг тусгасан болно. Үүнд:

1. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг үл хайхрах байдлыг илрүүлж таних, хариу үйлдэл үзүүлэх, цааш мэдээлэх
2. Багш, ажилтан, сайн дурын ажилчдын түүхийг шалгаж, сонгон авах
3. Насан хүрэгчид, хүүхдийн хоорондох харилцааг чиглүүлж өгөх Ёс зүйн дүрэмтэй байх
4. Аюулгүй орчин, үйл ажиллагааг бий болгох
5. Харьяа дүүргийн засаг захиргаа, холбогдох албан тушаалтантай холбогдох

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гарахаас урьдчилан сэргийлэх болон гарсан тохиолдолд хамгийн эрт үед нь илрүүлэх, хянан тогтоох, мэдээлэх ажлыг хийдэг идэвхтэй, аюулгүй орчныг бий болгож, бүрдүүлэх нь бидний зорилго юм. Америк дунд сургуультай холбоотой хүн бүр, мэргэжлийн багш ажилтнууд, гэрээт албан хаагч, сайн дурын ажилтнууд, сурагчид, эцэг эхчүүд бүгд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг үл хайхрах асуудлаар ойлголттой байж, үүний шинж тэмдэг, дохиог таньж мэддэг; олон улсын болон өөрийн улсын, орон нутгийн захиргаанд мэдээлэх, арга, үе шатыг мэддэг; хэрхэн, хэзээ, хэнд мэдээлэл хүргэх ёстой үүргээ ухамсарласан байхын төлөө бид төлөвлөн ажиллаж байна.

**<u>Нэгдүгээр зүйл: Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг үл хайхрах тухай түгээмэл буруу ойлголтууд болон бодит байдал</u>**

**Буруу ойлголт:** *Хүүхдийн хүчирхийллийг тухайн хүүхдийг үл таних хүмүүс үйлддэг.*
**Бодит байдал:** Хүүхдийн хүчирхийллийн 90%-ийг тухайн хүүхдийн гэр бүл, ойрын хүмүүс үйлддэг болох нь судалгаагаар илэрсэн.

**Буруу ойлголт:** *Хүүхдүүд хүүхэд хамгаалал гэсэн асуудлаар сонсож мэдэх нь аюултай.*
**Бодит байдал:** Зөв хөтөлбөрийн дагуу зохистой боловсрол олж авсан хүүхэд аюултай нөхцөл байдалтай тулгарахад өөртөө итгэлтэйгээр зөв хариу үйлдэл үзүүлэх магадлал дээшилдэг болох нь судалгаанаас харагдаж байна. Тодорхой хүн ам зүйн жишээ ашиглан заах нь хүүхэд өөрийгөө хамгаалж сурах чадварыг дээшлүүлдэг.

**Буруу ойлголт:** *Хүчирхийллийн тухай боловсрол гэж бэлгийн боловсролыг хэлнэ.*
**Бодит байдал:** Судалгаанд тулгуурласан тусгай хөтөлбөрүүд нь хүүхдүүд өөрсдийгөө хүчирхийлэгч этгээдээс гадна бусдад дээрэлхүүлэх, доромжлуулах зэрэг үйлдлээс хамгаалах чадвар, зан байдлыг хөгжүүлж өгдөг.

**Буруу ойлголт:** *Бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэл бол зарим улс орны соёлд байдаг л зүйл, тухайн соёлын нэг хэсэг.*
**Бодит байдал:** Хүүхдийн хүчирхийлэл ямар ч соёлд, хаана ч байж болшгүй зүйл!

**Буруу ойлголт:** *Хүүхдийн хүчирхийлэл ядуу буурай байдлаас бий болдог нийгэм, эдийн засгийн дорой байдлын үр дүн юм.*
**Бодит байдал:** Хүүхдийн хүчирхийлэл бүх төрлийн арьс өнгө, үндэс угсаа, нийгэм эдийн засгийн байдал, нийгмийн соёлын хэлбэрүүдэд тохиолддог болох нь судлагдсан.

**Буруу ойлголт:** *Олон улсын сургуулиуд орон нутгийн засаг захиргаанд хүчирхийллийн талаар мэдээлэх албагүй..*
**Бодит байдал:** Олон улсын сургуулиуд үйл ажиллагаагаа явуулж буй улс орныхоо хүүхэд хамгааллын хуулийн талаар мэдлэгтэй, түүнийг дагаж мөрддөг байх нь хууль, эрхзүйн хувьд тэдний үүрэг юм.

**Хоёрдугаар зүйл: Америк дунд сургуулийн баримтлах бодлого**

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг үл хайхрах байдал нь дэлхий даяарх томоохон асуудал юм. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг үл хайхрах байдал нь хүүхдийн эрхийн зөрчил бөгөөд хүүхдийн сурч боловсрох, бие мах бодь, сэтгэл санааны өсөлт хөгжилтөнд саад бэрхшээл учруулж буй явдал юм. Тиймээс манай сургууль Монгол улсын *Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиудыг даган мөрдөж ажилладаг болно.* Америк дунд сургуулийн бүх ажилтнууд нь хүүхэд хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртөж буй эсвэл өртөх эрсдэлд ойрхон байгаа гэж үзэх үндэслэлтэй шалтгаан байгаа л бол хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрах байдлын тохиолдлыг мэдээлэх ёстой. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрах байдлын сэжигтэй тохиолдлын талаар мэдээлэх, удирдлагын зүгээс дараачийн арга хэмжээг авах, хянах ажлыг энэхүү бодлогын хүрээнд явуулна.

Манай сургууль нь ямар нэгэн байдлаар хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртөж буй сурагчдын хувьд аюулгүй, найдвартай газар нь байхыг зорино. Үүний тулд энэхүү бодлогыг жил бүр эцэг эх нарт хүргэж, сурагчдад танилцуулан, ажилчдадаа мэдлэг мэдээлэл олгох болно. Манай сургууль хүүхдийн аюулгүй байдлыг хангахын төлөө ажилтан шалгаруулж авах журмаа жил бүр шинжилж, аливаа гомдол саналыг тусган, үр дүнтэйгээр шинэчлэн сайжруулна. Сургуулийн ажилтан буруутай этгээдээр сэжиглэгдсэн тохиолдолд, тухайн хүүхдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, бүрэн хэмжээний эрэн сурвалжлах үйл ажиллагааг зохион байгуулалттайгаар явуулна.

**Гуравдугаар зүйл: Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урдьчилан сэргийлэх, үүнд хариу үйлдэл үзүүлэх зааварчилгаа, урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

1. Хүүхэд Хамгааллын бодлогыг жил бүр эцэг эхчүүд, ажилтнуудад тарааж өгөх
2. Сургуулийн зүгээс эцэг эхчүүд, ажилтнууд, сурагчдад хүүхдийн эсрэг хүчирхийллийн (бие махбодийн, сэтгэл санааны, үл хайхрах) талаар нэгдсэн ойлголт өгөх
3. Сурагчид зохисгүй зан авирыг олж харж, таниж сурахад чиглэсэн хичээлүүдийг жил бүр зааж, хэлэлцүүлэг өрнүүлэх
4. Ажилтны Ёс Зүйн Дүрэм-ээр ажилтнуудын хүлээх хариуцлага, хил хязгаарын талаар тодорхой зааж өгөх
5. Сурагчид бие биедээ хүч үл хэрэглэх, дээрэлхэлтийн эсрэг журмуудыг тогтмол сурталчилж, хэрэгжүүлэх
6. Сургуулийн удирдлага ажилтан сонгон шалгаруулж авах аюулгүй ажиллагааны тодорхой журам гаргаж, хэрэгжүүлэх

***Хүүхдийг сонсоход өөрийгөө бэлтгэх нь:***

Сурагчдад хүүхэд хамгааллын талаар зааж, өөрийгөө тэдний хувьд итгэл найдвартай дэмжин туслагч болгосноор сурагчид асуудлаа өөрт чинь хэлнэ. Хүүхдүүд хүчирхийллийн талаар илчлэн хэлэх нь тэдэнд маш хэцүү байдаг гэдгийг ойлгож, зохистой хариу үйлдэл хэрхэн үзүүлэхээ сургуулийн ажилтан мэддэг байх хэрэгтэй. Сурагчид ихэвчлэн доорх төрлийн айдсаас шалтгаалан асуудлаа бусдад хэлж чаддаггүй:

**Дурсамж.** Хүүхдүүд ихэвчлэн аливаа хүчирхийллийн талаарх дурсамжаа “мартах”-ын тулд тэр тухай бодохгүйгээр орхихыг хичээдэг. Тэр тухай санахаар дахиад л сэтгэл нь өвддөг учраас тэр.

**Хайрлуулахаа болих.** Хүүхдүүд ихэвчлэн эцэг эх, найз нөхөд нь өөрт нь тохиолдсон хүчирхийллийн талаар мэдвэл өөрийг нь “бохир, муухай” гэж бодоод хайрлахаа болино гэж санаа зовдог. Үүнээс болж хүүхдүүд өөрсдийгөө буруутгадаг. Мөн хүүхдүүд өөрт тохиолдсон хүчирхийллийн талаар хүнд хэлвэл гэр бүлийнхнээсээ сална гэж айдаг.

**Ичгүүр, гэм буруу мэдрэх.** Хүүхдүүд аливаа хүчирхийллийг, ялангуяа насанд хүрсэн хүнтэй бэлгийн үйлдэл хийсэн үед энэ нь буруу гэдгийг зөнгөөрөө мэддэг. Гэвч бусдад юу болсныг хэлж, тийм юм болсон гэдгийг бататган ярих нь өөрт нь ичгүүртэй санагддаг. Бусдад хэлвэл өөрөө загнуулна, асуудалд орно гэж айдаг.

**Буруутгагдах.** Хүүхдүүд аливаа хүчирхийлэл өөрсдөөс нь болсон гэж буруутгагдана гэж айдаг. Ялангуяа бэлгийн хүчирхийлэл явагдсан үед өөрсдөө тэрэнд дуртай байсан гэж буруутгагдана гэхээс айдаг. Насанд хүрэгчдийн үг хүүхдийнхээс хүчтэй байдаг юм шиг санагддаг бөгөөд хүчирхийлэл үйлдэгч нь хүүхэд өөртөө хүргэхийг хүссэн, асуусан гэж мэлзэх нь элбэг.

**Гэмтээх.** Хүчирхийлэгч үйлдэгчид ихэвчлэн хохирогчдоо хүнд хэлвэл өөрсдийг нь, эсвэл гэр бүлийнхийг нь гэмтээнэ гэж айлган эрхшээлдээ байлгадаг. Тийнхүү хүүхдүүд гэр бүлийнхнийхээ аюулгүй байдалд хариуцлага хүлээх хэцүү ачааг үүрлээ гэж бодно.

****Хүчирхийлэгчийг илчлэхээс айх эдгээр шалтгааныг ойлгосноор хүүхдэд шаардлагатай тусламжийг үзүүлж чадна****

**<u>Дөрөвдүгээр зүйл : Буруутанг илчилсэн хүүхдэд хэрхэн туслах зөвлөмж</u>**

****Анхаарах: Багш нар бол буруутанг тогтоогч мэргэжилтнүүд биш юм. Таны үүрэг бол буруутанг илчилсэн хүүхдийг сонсож, сурагчид туслах дараагийн алхамыг тодорхойлох юм.***

- Хүүхэд танд нууцаа хэнд ч битгий хэлээрэй гэвэл битгий амлалт өгөөрэй. Хэрвээ та цааш мэдээлэх шаардлага гарвал, хүүхэд таныг итгэлийг нь эвдсэн гэж бодно.
- Хэрвээ хүүхэд тантай ярилцахыг хүсч буйгаа хэлвэл, өөр хүмүүс саад болохооргүй чимээгүй, тайван газар олохыг хичээ.
- Хүүхдийн яриаг чиглүүлж өгөх хэрэггүй. Өөрийнх нь үгээр тайлбарлуулж, яриаг нь сонс. Дэндүү нарийвчилсан, тодорхой яриулах гэж бүү шах.
- Тайван, энгийн хүлээж ав. Хүүхдийн ярьж буй яриа сонсоход хэцүү байлаа ч гайхаж балмагдсан, эвгүйцсэн, сандарсан байдал үзүүлэхгүй байх нь чухал.
- Хүчирхийлэл үйлдэгч этгээдийг шүүмжилсэн, буруутгасан үг хэлэх хэрэггүй. Учир нь тухайн хүн хүүхдийн хайртай, ойр дотны хүн байх нь элбэг.
- Бүх юм зүгээр болно гэж амлалт өгөх хэрэггүй.
- Хүчирхийлэл үйлдэгчтэй нүүр тулж уулзах хэрэггүй.
- Хэрвээ хүүхэд гэртээ харихыг хүсэхгүй байвал, энэ нь яаралтай арга хэмжээ авах шаардлагатай гэсэн үг. Сургуулийн удирдлагатайгаа шууд холбогдож, мэдээлэл өг. Хүүхдийг гэр рүүгээ авч явж болохгүй!
- Хүүхдийн хувийн нууцыг хадгал. Сургуулийн удирдлагад мэдэгдэнэ, харин бусад ажилтнуудтай мэдээллийг хуваалцаж болохгүй.
- Тухайн хүүхдэд туслахын тулд энэ талаар өөр хүнд хэлэх шаардлагатай гэдгийг тайлбарлаж өг.
- Тухайн хүүхэд өөрт тань ярьсан зүйлсээ өөр хүнд бас ярих хэрэгтэй болно гэдгийг тайлбарлаж өг.
- Дараа дараагийн үйл явцад хүүхдийг өөрийг нь оролцуулж, өөрт нь шийдвэрлэх эрх мэдэл өгч, зоригжуул.

**<u>Тавдугаар зүйл : Хэнд, хэзээ мэдээлэх вэ?</u>**

Сэжиглэгдэж буй хүчирхийлэл, үл хайхрах үйлдлүүдийн ихэнхийг сургуулийн захиргаа хянаж, зохицуулна. Жишээ нь:

1. Сурагчдын хоорондын харилцаа
2. Хүүхдийг эцэг эх нь гэртээ загнаж, шийтгэх
3. Хүүхэд, эцэг эхийн харилцаа
4. Хөнгөн зэргийн сэтгэлийн хямрал, өөртөө итгэлгүй байх, гашуудах зэрэг сэтгэл зүйн асуудлууд

Сургуулийн захиргаа, гадны байгууллага, оролцоотойгоор зохицуулах үйлдлүүд:

1. Удаан үргэлжилж буй, хүнд хэмжээний бие махбодийн хүчирхийлэл, үл хайхрах байдал
2. Бэлгийн хүчирхийлэлийн сэжиг бүхий үйлдэл

Гэр бүл нь хүчирхийллийг таслан зогсохгүй, хүүхдийн аюулгүй байдал хангагдах байх зэрэг ноцтой тохиолдолд мэдээлэх газрууд:

1. Орон нутгийн засаг захиргаа
2. Элчин сайдын яам, консулын газар

**<u>Зургаадугаар зүйл: Мэдээлэх болон арга хэмжээ авах үйл явц</u>**

Сургуулийн багш, ажилтан, албан хаагч бүгд бие махбодийн болон сэтгэл санааны аливаа хүчирхийлэл, дарамт, түрэмгийлэл, бэлгийн хүчирхийлэлийн үйлдлийг сургуулийн Сургалт хариуцсан захиралд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. Дараа нь сургуулийн Ерөнхий захиралд

мэдээлнэ. Сурагчид өөрсдөд болон бусдад тохиолдсон хүчирхийллийн аливаа үйлдэлийг мэдээлэхийг багш нар зөвлөнө. Сурагчдын өгсөн мэдээлэл амаар эсвэл бичгээр байж болно. Сургуулийн удирдлага тухайн үйлдлийн талаар мэдээлэл цуглуулж, огноо, оролцогч этгээд/этгээдүүд, мөн хамааралтай нэмэлт мэдээллүүдийг багтаан хавтаст хэрэг бичгээр үүсгэнэ. Хэрвээ ямар нэгэн төрлийн хүчирхийлэл үйлдэгдсэн гэх үндэслэлтэй шалтгаан байвал сургуулийн удирдлага энэхүү журмын дага шат дараатай үйл ажиллагаа явуулж, болсон явдлын талаар эрэн суравжилсан явц, үр дүнг баримтжуулан хадгална. Эдгээр үйл ажиллагааг (зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй) авч болно:

- Хамааралтай сурагчидтай уулзалт хийх
- Эцэг эхэд мэдээлэл хүргэх
- Эцэг эхтэй уулзалт хийх
- Тухайн үйлдэлтэй ямар нэг байдлаар хамааралтай хүмүүстэй уулзалт хийх, буруутгагдаж буй этгээдтэй уулзах
- Орон нутгийн засаг захиргаа, хүүхэд хамгааллын үйлчилгээний албаны хүмүүст хандах
- Орон нутгийн засаг захиргаанаас хууль ёсны арга хэмжээ авч, яллах
- Ажлын байрнаас түр түдгэлзүүлэх, чөлөөлөх (хэрвээ сургуулийн ажилтан бол)

**Үйлдэл сэжиглэгдсэний дараах үйл ажиллагааны дараалал**




## Долоодугаар зүйл: Хүчирхийллийн үйлдлийн талаар баримтжуулах нь

Аливаа хүчирхийллийн үйлдлийг баримтжуулсан хавтаст хэргийг манай сургууль хэрэгжүүлдэг, Сургуулийн бичиг хэрэг хөтлөлт, нууцлалын журмын дагуу хадгална. Олон улсын жишгээр хүүхэд хамгааллын тохиолдлууд тухайн хүүхэдтэй хамт сургуулиас сургуульд шилжин явдаг ба (ялангуяа асуудал гэр бүлийн хүрээнд бол) сургуулийн зүгээс бид тухайн хүүхдийн дараагийн очих сургууль хүүхдийг хамгаалахад чадах чинээгээрээ туслах нь бидний ёс суртахууны үүрэг юм. Сургуулийн элсэлтийн журам, үйл ажиллагаанд тухайн хүүхэд сургуулиас шилжих тохиолдолд тухайн хүүхдийн баримт бичгийг дараагийн сургуульд шилжүүлэн өгнө гэдгийг эцэг эхэд мэдэгдэнэ. Эцэг эхчүүд сургуультай гэрээ байгуулан гарын үсэг зурахдаа гэрээнд заасан сургуулийн нууцлалын бодлогыг хүлээн зөвшөөрч буйгаа илэрхийлж буй юм.

## Наймдугаар зүйл: Ажилтнуудын Ёс Зүйн Дүрэм

Америк дунд сургууль хүүхдийн аюулгүй байдлыг сахин, хүүхэд хамгааллын зарчмыг даган мөрдөж ажилладаг. Ажилтнуудын Ёс Зүйн Дүрэм нь манай сургуулийн төлөөлөл болсон багш, ажилтан, сайн дурын ажилтан, давтлагын багш, сурагчид ба сурагчидтай шууд харьцдаг, эсвэл бусдын хараа хяналтгүй харьцдаг бүх хүнд хамааралтай юм. Америк дунд сургуулийн нэрийн дор олон нийтийн ажил эрхэлж буй болон хувийн ажил хэргээ зохицуулж буй багш, ажилтан, сайн дурын ажилтан, давтлагын багш, сурагчид бүгд ямар нэгэн байдлаар бусдад үлгэр дууриал болж, урам зориг өгөх нь бий. Гэвч өөрийгөө зөв зохистой авч яваагүй тохиолдолд бусдад хохирол учруулж мөн болно. Тиймээс бид ямар ч үед өөрийн үйл хэргээ хөтлөхдөө үүрэг хариуцлагаа ухамсарлах ёстой юм.

Сургуулийн ажилтнууд өөрсдийн болон өрөөлийн эмзэг, сул талыг бодолцон, ялангуяа хүүхэдтэй ганцаарчлан ажиллаж байх үедээ, бие махбодь, сэтгэл санаа, бэлгийн харилцааны хил хязгаарыг маш нарийн бодолцож, хариуцлагатай хандах хэрэгтэй. Бэлгийн харилцааны ил, далд бүх үйлдлээс зайлсхийх шаардлагатай. Сургуулийн ажилтнууд бусад хүн, ялангуяа хүүхдийн биед хүрэх бол туйлын болгоомжтой хандаж, таны үйлдлийг нөгөө хүн хэрхэн хүлээж авах талаар бодолцох хэрэгтэй. Тухайн үйлдэл нь жирийн мэндчилгээ, халамж, анхаарал, баяр хүргэлт аль ч бай зөв зохистой эсэхийг нягтлана. Америк дунд сургуулийн бүх ажилтан, сайн дурын ажилтан бүгд ямар ч тохиолдолд хүүхдэд бие махбодийн шийтгэл оногдуулахыг хориглоно.

Хүүхэдтэй ганцаарчилсан уулзалт хийх бол, уулзалт олон нийтийн газар, бусад хүнд харагдахаар, эсвэл онгорхой хаалгатай өрөөнд болох ба уулзалтын талаар өөр нэг багш ажилтанд мэдэгдсэн байна. Хүүхдийн ямар нэгэн төрлийн хүчирхийлэл үйлдэгдсэн байх гэсэн үндэслэлтэй шалтгаан, эсвэл баримт байгаа нөхцөлд л ажилтнууд асуудлыг сөхөж гаргана.

Хүчирхийлэл, үйл хайхрах үйлдлийн сэжигтэй тохиолдол гарвал сургуулийн Хүүхэд Хамгааллын бодлогын дагуу сургуулийн удирдлагад мэдэгдэнэ.

Хүүхэдтэй харилцах харилцаа нь ил тод, нээлттэй, аюулгүй орчинд явагдана. Доорх журмуудыг дагаж мөрдсөнөөр Америк сургуулийн эцэг эх, сургуулийн удирдлага, багш, ажилтнууд, сайн дурын ажилтан, сурагчдын хоорондох хувийн, зохисгүй харилцаа гарах эрсдэл буурна:

- Сургуулийн ажилтан, сурагч хоёрын харилцаа зөвхөн мэргэжлийн хүрээнд, эсвэл сайн дурын ажлын хүрээнд (хичээл заах, спортоор дасгалжуулах гэх мэт...) явагдана. Түүнээс бусад төрлийн харилцааг хориглоно.
- Сургуулийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй этгээд болон насанд хүрээгүй хүүхэд хоёр харилцах шаардлагатай бол зөвхөн сургуулийн имэйл хаяг ашиглах.
- Сургуулийн сүлжээ, платформыг ашигласан цахим харилцааг тогтмол хугацаанд хянаж байх.
- Сургуулийн ажилтан, албан хаагч, сайн дурын ажилтнууд нийгмийн сүлжээний хэрэгсэл (Facebook, Twitter гэх мэт.) болон гар утасны текст мессеж ашиглан насанд хүрээгүй сурагчидтай харилцахыг хориглоно.

**<u>Есдүгээр зүйл: Ажилтнуудын Ёс Зүйн Дүрмийг даган мөрдөх мэдэгдэл</u>**

Америк дунд сургуулийн ажилтан би Америк дунд сургуулийн сурагч хүүхдүүдэд боловсрол олгох гэрээт үүргийнхээ хүрээнд Ажилтнуудын Ёс зүйн дүрмийг чанд даган мөрдөхөө амлаж байна.

**Би эдгээр үйлдлийг хийнэ:**

- Хүн нэг бүрт хүндэтгэлтэй, тэвчээртэй, шударга, найрсаг, нэр хүндийг нь хүндэлж, бодлоготой хандана.
- Өөр ямар нэгэн ажилтанд мэдэгдэхгүйгээр сургуулийн үйл ажиллагаанд хүүхэдтэй хоёулхнаа хамрагдахгүй.
- Хүүхдүүдтэй ажиллахдаа шүүмжлэл, хэт өрсөлдөөн, харьцуулалт зэргийг ашиглахгүй бөгөөд зөвхөн сурагчдыг дэмжих эерэг арга хэмжээнүүдийг ашиглана.
- Хүүхдийн биед хүрэх зайлшгүй шаардлагатай үед л хүрэх бөгөөд зөвхөн олон нийтийн дунд, бэлгийн бус байдлаар хүрч, хил хязгаарыг тогтмол барина.
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн сэжиг бүхий тохиолдлыг сургуулийн мэдээлэх бодлогын дагуу мэдээлнэ.
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн сэжиг бүхий тохиолдлыг эрэн сурвалжлахад бүх талаар хамтран ажиллана.

**Би эдгээр үйлдлийг хийхгүй:**

- Хүүхэдтэй бэлгийн, зохисгүй байдлаар ярилцахгүй, хүрэхгүй.
- Бие махбодийн болон сэтгэл санааны хүчирхийлэл ямар ч байдлаар үйлдэхгүй. Жишээ нь: цохих, алгадах, сэгсрэх, доромжлох, сүрдүүлэх, доош нь хийх.
- Хүүхэдтэй ажиллах үедээ утаат болон утаагүй ямар ч төрлийн тамхи авч явахгүй, татахгүй, согтууруулах ундаа, хууль бус эм, хар тамхи хэрэглээгүй байх.
- Өөрийн биш хүүхдийг гэрт нь хүргэж өгөхгүй
- Эцэг эх, асран хамгаалагчид нь мэдэгдэлгүйгээр, хүүхдээс бэлэг авахгүй, хүүхдэд бэлэг өгөхгүй
- Хүүхэдтэй гар утасны текст мессежээр, имэйлээр, фэйсбүүкээр, эсвэл ижил төрлийн цахим харилцааны хэлбэрээр харилцаа үүсгэхгүй. (Зөвхөн сургуулийн үйл ажиллагаатай холбоотой үед зөвшөөрнө.) (ASU’s Facebook)
- Ямар ч үед хүүхдийн хажууд хараал, зүхэл хэрэглэхгүй.

Би Америк дунд сургуулийн нэрийн дор хүүхэдтэй ажиллаж буй хүний хувьд гэмт хэрэгт холбогдож байгаагүйгээ батлах баримтыг өгөх үүрэгтэй. Би энэхүү Ажилтнуудын Ёс Зүйн Дүрэмтэй танилцсан ба дүрэм журмыг даган мөрдөхөө өөрийн гарын үсгээр баталгаажуулж байна. Би энэхүү Ажилтнуудын Ёс Зүйн Дүрмийг дагаж мөрдөөгүй ямар нэгэн үйлдэл гаргах, журамд заасны дагуу хийх ёстой үйлдлийг хийгээгүй тохиолдолд Америк дунд сургуулийн зүгээс надад сахилгын арга хэмжээ авах, цаашилбал намайг ажлаас чөлөөлөх үйлдэл хийхийг ойлгож байна.

Ажилтны нэр:_______________________________________________________

Ажилтны гарын үсэг:____________________________________________ Огноо:___________________

**ХАВСРАЛТ Ё: Student Check-out Form 2024-2025**

Student's name: ________________________________ Grade:____________________

REASON: (1) ____ GRADUATION Class of: ____________________

(2) ____ WITHDRAWAL Effective Date: ____________________

To be filled in and circulated by the subject teachers. Please write your name and signature AFTER a student returns all books and other material back to you.

| SUBJECT | TEACHER'S NAME | TEACHER'S SIGNATURE |
|---|---|---|
| English | | |
| Math | | |
| Social Studies | | |
| History | | |
| Science | | |
| Chemistry | | |
| Physics | | |
| Biology | | |
| Academic Counselor (HS)/Secondary School Coordinator (MS) | | |
| PE and Health | | |
| Visual Arts | | |
| Drama/Dance | | |
| Music | | |
| ELL | | |
| Mongolian | | |

| | | |
|---|---|---|
| Chinese/French | | |
| Computer Science | | |
| Business | | |

**_____ Homeroom Teacher (to be completed once all subject teachers have been signed):**

_____ All books and other materials returned

Homeroom teacher's name: ___________________ Signature: _____________________

---

Library:

____All borrowed materials returned ____________________________ Fee to be refunded for damaged or lost books MNT/$ ____________________________

Librarian's name: __________________ Signature: _____________________

---

Cafeteria:

____Account clear:(________________________________)

Cafeteria staff: __________________ Signature: _____________________

---

Parents/Guardians/ Эцэг эх/Асран хамгаалагч

Reason to transferring your child/Хүүхдээ шилжүүлэх болсон шалтгаан:______________________

__________________________________________________________________________________

__________________________________________________________________________________

__________________________________________________________________________________

__________________________________________________________________________________

Please check one/Аль нэгийг нь сонгоно уу:

- ☐ **To private school** (If YES, please indicate name of school)/**Хувийн сургуульд** (Хэрэв тийм бол сургуулийн нэрийг доор бичнэ үү)

__________________________________________________________________________

- ☐ **To public school** (If YES, please indicate name of school)/**Улсын сургуульд** (Хэрэв тийм бол сургуулийн нэрийг доор бичнэ үү)

______________________________________________________________________________

☐ **Moving abroad** (If YES, please indicate name of country)/**Бусад улсруу шилжих** (Хэрэв тийм бол орны нэрийг доор бичнэ үү)

______________________________________________________________________________

Bank account number for refund/Барьцаа мөнгө буцаан олгох дансны мэдээлэл:

Bank/Банк: ______________________

Account number/Дансны дугаар: ______________________

Beneficiary/Хүлээн авагч: ______________________

Parent Signature/Эцэг эхийн гарын үсэг:______________________

Date/Он сар өдөр__________________________

______________________________________________________________________________

**Student Services:**

**Note:**______________________________________________________________________

______________________________________________________________________________

______________________________________________________________________________

______________________________________________________________________________

______________________________________________________________________________

______________________________________________________________________________

___ Letter of student withdrawal (Date received: ____________________ )

___ Three transcripts One letter of attendance:(_____________________________________________)

Student Services Office: Name _______________________ Signature: ___________________

Accountant:

Student’s name: ________________________________ Grade:____________________

Fees and other charges have been paid:

____Registration

Tuition: ____ 1st Semester ____ 2nd Semester
____ Bus ____ Library fee (₮ __________)

Cap and Gown: ____ Deposit ____ Bought

Justification of other refunds: __________________

**Refund calculation:**

Tuition fee refund: ________
Book deposit refund: _____
Bus payment refund: _____
Library fee: _______
Other fee 1: ___________
**Total refund:** ___________

Accountant’s name: ____________________ Signature: ____________________

---

Managing Director:

Approved by: ________________________________ /D. Oyunsuren/ Date: _____________

## ХАВСРАЛТ Ж: Ахлах дунд сургуулийн хөгжмийн зэмсэг түрээслэх

Сурагчийн нэр: ____________________________________________________

Хөгжмийн зэмсэг: __________________________________________________

Эцэг эхийн нэр: ____________________________________________________

Эцэг эхийн утас: ___________________________________________________

Эцэг эхийн цахим хаяг: _____________________________________________

1. Хөгжмийн зэмсэг түрээслэх барьцаа **50,000₮**. Түрээсийн төлбөр **50,000₮**. Хөгжмийн зэмсэг авахаасаа өмнө дээрх хоёр төлбөрийг хамт төлнө. Сурагч сургуулиас гарах үед хөгжмийн зэмсгээ буцааж өгсний дараа төлбөрийн тодорхой хэсгийг буцаан олгоно. Буцаах дүнг тухайн зэмсгийн нөхцөл байдал болон хичээлийн жилд үлдсэн сарын тооноос хамааруулан тооцно. Түрээсийн төлбөр нь дараагийн хичээлийн жилд  хөгжмийн зэмсгийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслийг шинээр авах зардалд зарцуулагдана.

2. Зуны хөгжмийн хөтөлбөрт ашиглахаас бусад тохиолдолд сурагчдад зун амралтын үеэр хөгжмийн зэмсэг түрээсээр олгохгүй.

3. Сургуулийн хөгжмийн зэмсэг, хэрэгслийн хэвийн элэгдлээс бусад бүх **гэмтлийг** сурагч хариуцна. "**Хэвийн элэгдэл"** гэж юу болохыг Америк сургуулийн Хөгжмийн тэнхим тодорхойлно.

4. Сурагч болон эцэг эх нь хөгжмийн зэмсэгийг авсан үеийнхтэй адилхан нөхцөлд буцааж өгөх үүрэгтэй (хэвийн элэгдэлтэй байж болно).

5. Хэрэв хөгжмийн зэмсэг гэмтсэн бол тэр даруй хөгжмийн багшид мэдэгдэх нь сурагч, эцэг эхийн үүрэг юм. Хөгжмийн багш дараагийн арга хэмжээг тодорхойлно. СУРАГЧ/ ЭЦЭГ ЭХЧҮҮД ЯМАР Ч ЗАСВАР <u>**ХИЙЖ БОЛОХГҮЙ**</u>. Зөвхөн хөгжмийн зэмсэгийн мэргэшсэн засварчид засвар хийх эрхтэй. Эдгээр засварын өртөг нь ердийн элэгдлээс давсан зардлыг сурагч, эцэг эх хариуцна.

6. Хөгжмийн зэмсэг нь засварлах боломжгүй болтлоо гэмтсэн тохиолдолд тухайн сурагч, эцэг эх нь сургуульд бүрэн орлуулах хэмжээний төлбөрийг төлөх үүрэгтэй. Сурагч болон эцэг эх нь гэмтсэн зэмсгийг болон бусад хэрэгслийг засах эд ангид ашиглах зориулалтаар сургуульд буцааж хандивлах боломжтой.

7. Сурагч /эцэг эх нь уг зэмсгийг өөр этгээдэд зээлдүүлэхгүй, зарахгүй.

8. Сурагч бусад сурагчдад, найз нөхөд, хамаатан садандаа уг зэмсгийг ашиглахыг зөвшөөрөхгүй.

9. Сурагч хөгжмийн зэмсгийн аюулгүй байдлаар тээвэрлэх ёстой (жишээлбэл, дугуй, скейтборд гэх мэтээр авч явахыг хориглоно)

10. Сурагчдад хөгжмийн зэмсгийн арчилгаа, засвар үйлчилгээний талаар зааварчилга өгөгдөх бөгөөд сурагч эдгээр заав족ыг дагаж мөрдөх ёстой.

11. Хэрэв хөгжмийн багш тухайн хөгжмийн зэмсгийг зүй бусаар ашиглаж байгааг анзаарсан, эсвэл ямар нэгэн шалтгаанаар сурагчийг ангиас нь хасвал уг хэрэгслийг сургуульд буцааж өгнө. Шаардлагатай тохиолдолд төлбөрийг засвар үйлчилгээнд зарцуулна. Сурагч зэмсгийн хайрцаг дээр сурагчийн нэр, хаяг, сургуулийн нэр бүхий тодорхой тэмдэглэгдсэн шошгыг үргэлж хадгална.

12. Зуны амралтаас өмнө хөгжмийн зэмсгээ сургуульд буцааж өгнө.

*ЖИЧ: Хөгжмийн зэмсгийн арчилгаа, засвар үйлчилгээний мөнгө төлөгдөөгүй тохиолдолд сурагчийн номын барьцаанаас суутгах болно.*

*Би Улаанбаатар дахь Америкийн сургуулийн хөгжмийн зэмсгийн хэрэглээний талаарх эдгээр бүх нөхцөлийг анхааралтай уншсан бөгөөд эдгээр нөхцлийг дагаж мөрдөхийг зөвшөөрч байна.

ЭЦЭГ/ЭХИЙН ГАРЫН ҮСЭГ________________________________________________

СУРАГЧИЙН ГАРЫН ҮСЭГ _______________________________________________

Зэмсэг: ______________________ Бранд: ______________________

Төлөв: _______________________________________

Дугаар:( байгаа тохиолдолд) ______________________________

Орлуулах үнэ: ___________________

Авсан огноо: _______________ Буцаасан огноо: _____________

**ЭНЭ ХУУДСЫГ ХӨГЖМИЙН БАГШДАА ХУРААЛГАЖ ТӨБӨРИЙГ САНХҮҮГИЙН АЛБАНД ТӨЛНӨ ҮҮ.**

## ХАВСРАЛТ 3: Америк Дунд Сургуулийн Биеийн Тамирын Тэнхимийн Зорилго ба Шаардлага

Америк дунд сургуулийн биеийн тамирын тэнхимын эрхэм зорилго нь сурагч бүр спортоор хичээллэснээр багаар ажиллах, өрсөлдөх чадвартай, өөрийгөө дайчлах, үнэнч шударга тоглох, улмаар оюун санаа, бие бялдар, сэтгэлзүйн хаттай иргэн болж төлөвшихөд чиглүүлнэ.

АСУ Биеийн тамир эрүүл мэндийн тэнхим нь дунд сургуулийн биеийн тамирын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхим юм. Манай сургуулийн багш ажилчид Сурагч-Тамирчныг сургуулийнхаа Алсын хараа, Зорилго болон Сурагчийн заавал эзэмших чадвар болох ESSO зэрэг дээр суурилан улам хөгжүүлэхийг зорьж ажилладаг билээ.

**Боловсролд суурилсан атлетик гэж юу вэ?**
Боловсролд суурилсан атлетик нь "сурагч-тамирчид"-ын сурлага, зан төлөв, манлайлах шинж чанарыг хөгжүүлэх, сургууль хоорондын биеийн тамирын холбоотой зохих хэмжээнд хамтарч нийгмийн сэтгэл зүйг нь дэмжих зэрэг боловсролын туршлагыг баяжуулах платформ юм. Манай тэнхим нь сурагчдыг амжилттай суралцах зорилгодоо хүрэхэд нь нэмэр болохын зэрэгцээ насан туршийн чанартай сургамж, туршлага олгох багийн спортын үйл ажиллагааг дэмжиж ажилладаг.

**Сурагч** - сурч боловсорч мэдлэгээ өргөжүүлэн судалж түүндээ дүгнэлт хийж буй нэгэн билээ.

**Тамирчин** - "спортоор мэргэшсэн" бусад биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийдэг, "дунджаас дээгүүр" бие бялдрын чадвартай, спортын онцлог ур чадвар, стратеги-т сургагдсан хүн.

**Биеийн тамир тэнхимийн Сурагч-Тамирчдын эзэмших үнэт *зүйлс* ба *зарчим*:**

- Хүн бүртэй ёс зүйтэй харьцах;
- Хариуцлагатай байх/өөрийгөө болон бусдыг хүндэтгэх;
- Бэрхшээлтэй тулгарах үедээ хамгийн эерэг хандлагыг ашиглах;
- АСУ-Алсын хараа, Зорилго болон Сурагчийн заавал эзэмших чадвар болох ESSO зорилтуудыг өдөр бүр эрхэмлэн дээдэлж, "иргэний эрхэм чанар" -ыг ашиглан хэрэгжүүлж байх;
- АСУ-ны хамт олондоо, гэр бүлдээ үнэнч, халамжтай, шударга зан чанараа харуулж байх;
- Тэд "шударгаар" эрдэм мэдлэгээ сайжруулахын зэрэгцээ спортын хувьд илүү их амжилт гаргахад "ямар ч шалтаг" байхгүй гэдгийг ойлгодог байх;

1. **<u>Спортын хөтөлбөрүүд</u>**

   ***1.1. Дунд ангийн сурагчдын спорт (13 болон 15 наснаас доош нас)***

   - Хөл бөмбөг, хавар
   - Сагсан бөмбөг, өвөл
   - Гар бөмбөг, намар

   ***1.2. Ахлах ангийн сурагчдын спорт (19-өөс доош нас)***

   - Хөл бөмбөг, хавар
   - Сагсан бөмбөг, өвөл
   - Гар бөмбөг, намар

   ***1.3. Олон улсын сургуулиудын холбооноос зохион байгуулдаг тэмцээн.***

   Шалгарсан тамирчдыг сургуулиа төлөөлүүлэн олон улсын тэмцээнд оролцуулна. *<u>Багийн гишүүнээр сонгогдсон сурагчид аяллын зардлыг өөрсдөө төлөх бөгөөд Биеийн Тамирын танхимын эрхлэгчийн заасан хугацаанд зохих төлбөрийг гүйцэтгэхийг шаардана.</u>*

2. **<u>Тамирчдын багт орох шалгуур</u>**

   ***2.1 Нас***

   2.1.1 Ахлах ангийн тамирчин 15-аас дээш настай, 9-12 ангийн сурагч байна. Зарим тохиолдолд 8-р ангийн буюу 15 нас хүрээгүй сурагчид оролцох боломжтой. Шалгаруулахаас өмнө тухайн сурагчийн бие даалт, сурлага, бие бялдрын хөгжил болон бусад хүчин зүйлсийг харгалзан сонгоно.

   2.1.2 Дунд ангийн сурагч-тамирчин 6-8-р ангийн сурагч байна.

   ***2.2 Дүн***

   **Хоёр долоо хоног тутмын дүнгийн явц**

   Сурагч-тамирчид бүх хичээлд 70% доошгүй дүнтэй байх. Хэрэв хоёр долоо хоног бүрийн дүнгийн явц дээр аль нэг хичээлд 70%-иас доош үнэлгээ авсан бол эцэг эхэд нь мэдэгдэж дунд сургуулийн координатор эсвэл зөвлөх багштай хамтран нэмэлт давтлага өгнө. Уг нэмэлт давтлага дүн нь сайжрах хүртэл долоо хоногт дор хаяж нэг удаа байх болно.
   Хуваарийн дагуух нэмэлт давтлагыг (7 хоногт нэг удаа) болон спортын бэлтгэлийг (7 хоногт 2 удаа) урьдчилан мэдэгдэж чөлөө авалгүй ирээгүй тохиолдолд “тасалснаар” тооцно. Спортын улирлын үед 2 удаагийн нэмэлт давтлага болон спортын бэлтгэлийн таслалт нь сурагчийг багаас хасахад хүргэнэ. Багийн дасгалжуулагч багш сонгогдсон сурагч-тамирчдад хяналт тавьж ажиллана.

   **Улирлын Дүн**

   Хэрэв сурагч-тамирчин улирлын эцсийн дүнгээр аль нэг хичээл дээр 60%-иас доош дүнтэй гарвал автоматаар шаардлага хангахгүй болж, дүн нь тэнцэх хүртлээ спортын багтайгаа тоглох эрхгүй болно.

*2.3 Ирц*

2.3.1 Сурагч-тамирчин багт гишүүнээр орохын тулд хичээлдээ тогтмол явах, идэвхтэй сайн суралцахыг шаардана. Тогтмол хоцордог, 2-аас дээш өдөр хичээлд суугаагүй сурагчийг багаас гаргана.

2.3.2 Тэмцээний бэлтгэлийн үеэр сургуулиас чөлөө авах, хичээл тасалсан сурагчдыг багт оруулахгүй, мөн аялан тоглох тэмцээнд оруулахгүй байх арга хэмжээ авна.

2.3.3 Аливаа олон улсын спортоос нэг жил хүртэл хугацаанд чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.

*2.4 Багын тамирчин сонгох*

Багт оролцох хүсэлтэй сурагчид шалгаруулалт болох бүх өдөр ирсэн байх ёстой. Энэ өдөр тамирчид тавих шаардлагыг танилцуулна. Тэдгээр шалгууруудыг хангах нь тухайн тамирчин-сурагчийн үүрэг юм. Тухайн багт сонгогдоогүй сурагчид бусад спортын төрөл эсвэл хичээлээс гадуурх дугуйланд хамрагдах боломжтой.

3. **<u>Багийн гишүүдийн Ёс зүйн хэм хэмжээ</u>**

*3.1 Тамирчны сахилга бат*

Бүх тамирчин сурагчид дараахи сахилга батын хэм хэмжээг мөрдөнө:

3.1.1 Бусад тоглогчид болон дасгалжуулагч нарт шударга хүндэтгэлтэй хандана.

3.1.2 Дүрмийн дагуу тоглоно.

3.1.3 Өөрийгөө хянах чадвартай байх, бүдүүлэг үг яриа хэрэглэхгүй.

3.1.4 Зөвхөн англиар ярина.

3.1.5 Багийн тоглогч байж багтайгаа хамтарч тоглоно.

3.1.6 Өмнө нь ямар нэгэн байдлаар хүмүүжлийн доголдол гаргасан тохиолдолд (анги танхимдаа, спортын зааланд, сургуулийн коридорт болон хоолны газарт) сахилга батын гэрээ хийх шаарлагатай.

*3.2 Дасгалжуулагчийн сахилга бат*

**Чадвар**: Дасгалжуулагч багш өөрийн ур чадвар хэм хэмжээг мэддэг байх. Мөн дасгалжуулагчийн гэрчилгээжүүлэлт (NFHS), сургалтанд хамрагдсан байх. Дасгалжуулагчийн туршлагатай, спортын дасгалжуулагчийн техникийг ашиглах чадвартай байх ёстой.

**Шударга байдал:** Дасгалжуулагч багш нь Америк дунд сургуулийн болон бусад сургуулийн хамт олонтой шударга хүндлэлтэй харьцана. Дасгалжуулагч өөрийн үйлдэл, зан авирыг сурагчдад үлгэр дууриалал болно гэдгийг ойлгодог, үйлдлээ үргэлж анхаарч, АСУ-ийн сургалтын болон спортын хөтөлбөрийг хариуцдаг хүмүүсийн өгсөн үүрэг даалгаврыг дагаж мөрдөх ёстой.

**Тамирчдыг хүндлэх:** Дасгалжуулагч багш тамирчдын үндсэн эрх, нэр төр, үнэ цэнийг хүндэтгэх ёстой. Дасгалжуулагч багш нь нас, хүйс, арьсны өнгө, үндэс угсаа, үндэстний

гарал, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, хэл яриа, нийгэм эдийн засгийн байдал зэрэг соёлын, хувь хүний ялгааг мэддэг байх ёстой.

**Бусдын төлөө:** Дасгалжуулагч багш нь тамирчид болон хамтрагчдынхаа сайн сайхны төлөө хувь нэмэр оруулахыг эрмэлздэг байх. Аливаа маргаан зөрчил гарах үед зөрчлийг арилгах, хор уршгаас зайлсхийх үүрэг хариуцлагаа ухаарч хичээж ажиллах хэрэгтэй.

**Дасгалжуулагчийн хариуцлага:** Дасгалжуулагч багш нь АСУ-ын хамт олны өмнө хүлээсэн үүрэг мөн ажиллаж амьдарч буй нийгмээ ухамсарладаг байх. Мөн бусдын сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулан спортын талаарх мэдлэгээ олон нийтэд түгээдэг байх. Дасгалжуулагч багш нь сургуулийн ёс зүйг түүнчлэн Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмыг дагаж мөрдөж ажлаа зүй бусаар ашиглахгүй байх ёстой.

### *3.3 Тамирчны ёс зүй*

Шударга тоглож, шударгаар ялж, ялагдахыг заах нь сургуулийн спортын хөтөлбөрийн нэг чухал хэсэг юм. Тиймд сурагчид тамирчин хувь хүнд байвал зохих чадваруудад суралцах шаардлагатай. Сөрөг үг хэлэх, хандлага гаргах, сэтгэл хөдлөл илэрхийлэх зэрэг орно.

### *3.4 Багаас гарах*

Багаа дундаас нь хаясан сурагч тухайн хичээлийн жилд дахин багт орох эрхгүй болно. Иймд шинээр багт сонгогдсон тухайн сурагч өөр бусад сурагчдын орон тоог авсан гэдгээ ухамсарлах хэрэгтэй. Мөн багийн гишүүн байна гэдэг нь бусад гишүүдийн хичээл зүтгэл, оролцоо, дүрмийг дагах нь тухайн сурагчаас хамааралтай гэдгийг санах хэрэгтэй.

### *3.5 Тамирчин өөрийгөө дайчлах*

Багийн тамирчин бүр:

- Багийн бүх тоглолтонд тамирчин өөрийгөө дайчлах, бэлтгэл, дадлага, тоглолт хийх, уулзалтанд оролцох
- Багийн идэвхтэй тоглогч, сургуулийн нэг хэсэг байхын төлөө өөрийгөө дайчлах
- Тамирчны ур чадвараа байнга сайжруулах
- Багийн тоглолтонд өөрийгөө болон бусад гишүүдээр бахархах

### *3.6 Тамирчдын тээврийн асуудал*

- Хол ойроос үл шалтгаалан аливаа спортын арга хэмжээнд шаардлагатай тээврийн хэрэгслийг сургуулиас зохион байгуулна.
- Сурагч өөр унаагаар зорчих тохиолдолд эцэг эхийн гарын үсэг бүхий зөвшөөрлийн бичгийг дасгалжуулагч болон спорт хариуцсан багшдаа өгөх ёстой.

### *3.7 Тамирчдын хувцас хэрэгсэл*

3.7.1 Сурагчид бэлтгэлд өөрсдийн хувцсыг өмсөнө. Тэмцээнд өмсөх хувцсыг сургуулиас хангана.

3.7.2 Сургууль спортын шаардлагатай тоног хэрэгслээр хангана.

3.7.3 Спортын улирал дууссан дараагийн долоо хоногт багтаж сурагч сургуулиас өгсөн хувцас, тоног хэрэгслийг угааж цэвэрлэн буцаана.

### *3.8 Тамирчны эрсдэл:*

3.8.1 Сурагчид аливаа спортын бэлтгэл, дасгал сургуулилт, тэмцээн зэргийн үеэр гэмтэл бэртэл авах эрсдэлтэй. Сурагч тамирчин нь аливаа спортын тэмцээн, багийн шалгаруулалт зэрэгт оролцохоос өмнө олон улсын эмнэлгийн зөвшөөрөл бүхий эмчийн гарын үсэгтэй PPE буюу тэмцээн уралдаан, спортын үйл ажиллагаанд оролцохын өмнөх эмчийн магадалгааг сургалтын албанд авчирвал зүйтэй.

Дээрх PPE магадалгааг багийн шалгаруулалтын өмнө авах нь сурагчийн аюулгүй байдлыг хангаж доорх үзүүлэлүүтийг харах, багт орох боломжтой эсэхийн мэдэх зорилготой юм.

- Тамирчны ерөнхий эрүүл мэнд
- Тамирчны одоогийн эрүүл мэнд
- Одоо ямар нэгэн гэмтэл бэртэл байгаа эсэх
- Тамирчны гэмтэл авах эрсдэлийг нэмэгдүүлэх нөхцөл байдал байгаа эсэхийг
- Тамирчны бие бялдрын төвшин

3.8.2 Спортын арга хэмжээ, бэлтгэлийн үеэр гэмтэж бэртсэн тохиолдолд сурагч энэ талаар дасгалжуулагч, спорт хариуцсан багшид яаралтай мэдэгдэнэ. Гэмтэл бэртэлийн дараа аливаа спортын арга хэмжээнд дахин оролцох эрхийг улсын эмнэлгийн зөвшөөрөл бүхий эмчийн бичиг дээр үндэслэн олгоно.

Би УАС-ийн Биеийн тамирын тэнхимийн эрхэм зорилго, ёс зүйн дүрмийг уншиж танилцсан бөгөөд хүлээн зөвшөөрч байна.

Сурагчийн гарын үсэг: ______________________Спортын төрөл: __________________________

Дармал үсгээр бичих:__________________________________________________

Эцэг эхийн гарын үсэг: ______________________________ Date:_______________________________

Дармал үсгээр бичих____________________________________________

**ХАВСРАЛТ И: Сургуулийн орчинд дотно үерхлийн**

**сэтгэл хөдлөлөө зүй зохистой илэрхийлэх**

УАС нь хоёр сурагчийн хооронд хайр сэтгэлийн мэдрэмж байж болохыг хүлээн зөвшөөрдөг. Гэсэн хэдий ч сургуулийн байранд эсвэл сургуультай холбоотой үйл ажиллагаанд оролцохдоо олон нийтийн дунд биеэ зохистой авч явах ёстой.

Сургуулийн байранд дотно байдлаа хэт их ил харуулах нь зохисгүй юм. Бие биедээ хандах мэдрэмжээ илэрхийлэх нь хоёр хүний хувийн асуудал тул ойр орчимд тань байгаа хүмүүстэй хуваалцах шаардлагагүй ба ойр орчимд байгаа хүмүүсийг тухгүй байдалд оруулж, харж байгаа хүмүүсийн анхаарлыг сарниулах юм.

**Доорх дотно үерхлийн сэтгэл хөдлөлөө зүй зохисгүй илэрхийлэх зарим жишээг харна уу, мөн үүгээр хязгаарлагдахгүйг анхаарна уу:**

- тэврэлт
- үнсэлт
- хөтлөлт
- нүүрэнд хүрэх
- нэгнийхээ өвөр дээр суух
- хөлөө нэгнийхээ өвөр дээр тавих
- Сургуулийн байрны аль нэг өрөө/хэсэгт зөвшөөрөлгүй орж "хувийн" мэдрэмжээ илэрхийлэх

Дотно үерхлийн сэтгэл хөдлөлөө зүй бус харуулахыг зөвшөөрөхгүй ба эдгээр үйлдэл нь эцэг эхийн хурал хийх, анхааруулга авахад хүргэнэ. Хэрэв сануулга авсан ч дахин үргэлжилбэл сургуулиас түдгэлзүүлэх боломжтой. Бусдыг хайрлах сэтгэлээ илэрхийлэх нь хоёр хүний хувийн асуудал бөгөөд тэдний эргэн тойрон дахь бусдад нөлөөлөх ёсгүй юм. Тиймээс бусдыг хүндэтгэх нь зөв сахилга бат юм.

Би дээрхийг уншиж, сургуулийн журмыг дагаж мөрдөхгүй байх нь ямар үр дагаварт хүргэхийг бүрэн ойлгож байна.

Сурагчийн нэр:

Анги/Бүлэг:

Сурагчийн гарын үсэг ____________________________

Сургалт хариуцсан захирлын гарын үсэг____________________________